Дээрх томьёогоор уг автомашины 100 км гүйлт дэх үндсэн нормыг хөдөлгөөний эрчмийн нэмэгдэл, хүйтний улирлын 2 дугаар бүсийн 10 хувийн нэмэгдлээр нэмэгдүүлэн тооцвол;

$$Q_n = N_V * \frac{S}{100} * (1 + \sum_{i=1}^n K_i) = N_V * \frac{S}{100} (1 + K_T + K_x) = 8,0 * \frac{100}{100} (1 + 0.2 + 0.1) = 10,4 \text{ л}$$

Хүйтний улирлын 2 дугаар бүсийн 20 хувийн нэмэгдлийг тооцвол;

$$Q_n = N_V * \frac{S}{100} * (\sum_{i=1}^n K_i) = 8,0 \text{ л} * \frac{100}{100} (1+0,2+0,2) = 11,2 \text{ л}/100 \text{ км}$$

Жишээ 4 Хүйтний улиралд Улаанбаатар – Зуун мод – Улаанбаатар чиглэлийн 86 км замд ажилладаг Аэро сити 540 маркийн автобусны шатахуун нормыг тодорхойлбол;


Өгөгдсөн нь $N_V = 29.5 \text{ л}$, $S = 86 \text{ км}$, $K_T = 0$, $K_3 = 0$

1. 10 дугаар сарын 15-наас 11 дүгээр сарын 15, 2 дугаар сарын 16-наас 4 дүгээр сарын 10 хүртэл 10%-иар тооцвол;

$$Q_n = N_V * \frac{S}{100} * (1 + \sum_{i=1}^n K_i) = 29,5 * \frac{86}{100} (1 + 0.1) = 27,91 \approx 30,0 \text{ л}/86 \text{ км}$$

2. 11 дүгээр сарын 16-наас 2 дугаар сарын 15 хүртэл 20%-иар тооцвол;

$$Q_n = N_V * \frac{S}{100} * (1 + \sum_{i=1}^n K_i) = 29,5 * \frac{86}{100} (1 + 0.2) = 30,44 \approx 31,0 \text{ л}/86 \text{ км}$$



Жишээ 5 Хүйтний улиралд /1 дүгээр сарын 15-ны өдөр/ Улаанбаатар хотоос Архангай аймгийн Цэцэрлэг сум хүртэл 3 тн ачаатай явах Mitsubishi Canter маркийн автомашины олговол зохих шатахуун зарцуулалтыг тооцвол;

Өгөгдсөн: $N_Y = 12.7 \approx 13,0$ л, $S = 470$ км, $K_T = 0$, $K_3 = 0$, $K_x = 0,2$

$$W = G * S = 470 \text{ км} * 3 \text{ тн} = 1410 \text{ тн.км}$$

Энэхүү тушаалын 2 дугаар хавсралтын 2,4-т Дизель түлшээр ажилладаг автомашины 100 тн.км тээврийн ажил тутамд 1,725 л шатахуун олгохоор заасан буюу $N_{\text{тн.км}} = 1.725$ л байна.

Дээрх өгөгдлийг үндэслэн томъёо 10-р уг автомашинд олгох шатахуун зарцуулалтын нормыг тооцвол;



$$Q_n = N_Y * \frac{S}{100} (1 + \sum_{i=1}^n K_i) + N_{\text{тн.км}} * \frac{W}{100} = 13,0 \text{ л} * \frac{470}{100} * (1 + 0,2) + 1,725 * \frac{1410}{100} = 97,64 \approx 98,0 \text{ л}$$

Жишээ 6 Дулаан улиралд North Benz загварын ачааны автомашин А маркийн чиргүүлтэй /чиргүүлийн жин 4 тн/ 350 км замд 40 тн-ийн ачааг тээвэрлэх эд олгох шатахуун зарцуулалтын нормыг тооцъё.

Өгөгдсөн нь: $N_c = 35,0$ л, $S = 350$ км, $K_T = 0$, $K_3 = 0$, $K_x = 0$, $N_{\text{тн.км}} = 1,725$ $G = 4$ тн гэсэн өгөгдлөөс эхлээд уг автомашины чиргүүлтэй ажилласан 100 км сул гүйлтэд зарцуулах шатахууныг хэмжээг тооцвол;

$$N_Y = N_c + N_q G = 35,0 \text{ л} + 1,725 * 4 = 41,9 \approx 50 \text{ л/100 км}$$

$$Q_n = N_Y * \frac{S}{100} (1 + \sum_{i=1}^n K_i) + N_{\text{тн.км}} * \frac{W}{100} = 50 \text{ л} * \frac{350}{100} * 1 + 1,725 * \frac{350 * 40}{100} = 416,5 \text{ л}$$



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 сарын 30 -ний өдрийн 390 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

АВТОМАШИНЫ ЭДЭЛГЭЭНИЙ НӨӨЦИЙН ДООД ХЯЗГААР БУЮУ ГҮЙЛТИЙН НОРМ

- 4.1. Аж ахуй нэгж, байгууллага, иргэд нь автомашины эдэлгээний нөөцийн доод хязгаарын буюу гүйлтийн нормыг үйлдвэрлэгчийн болон судалгааны үндсэн дээр тогтоосон автомашины эдэлгээний гүйлтийн доод хязгаарыг үндэс болгон өөрсдөө тогтоож мөрдөнө.
- 4.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь автомашины эдэлгээний гүйлтийн нормыг ашиглалтын бүс, тээвэрлэлтийн нөхцөл, ачааллаас хамааруулан доорх хувиар хорогдуулан тооцож болно.
- 4.2.1. Авто замын нөхцөлөөс хамааруулж автомашины эдэлгээний гүйлтийн нормыг бууруулах хувь хэмжээ:

№	Авто замын нөхцөл, ердийн хөрсөн зам	Бууруулах хувь хэмжээ
1	Баян-Өлгий, Увс, Хөвсгөл, Завхан, Ховд, Говь-Алтай аймгийн нутагт	10,0
2	Өмнөговь, Архангай, Булган, Сэлэнгэ аймгийн нутагт	5,0
3	Ашиглалтын хүнд нөхцөлд (уулнаас мод цагаалах, тариан талбайд ажиллах, замгүй газраар хайгуулын ажилд явах, уул уурхайн карьерт ажиллах зэрэг нөхцөлүүд орно)	15,0


- 4.2.2. Автомашины төрөл ачааллаас хамааруулж автомашины эдэлгээний гүйлтийн нормыг бууруулах хувь хэмжээ:

№	Автомашины төрөл, ачаалал	Бууруулах хувь хэмжээ
1	Хоёр голт чиргүүлтэй ажиллавал	15,0
2	Хоёр голт, хоёр чиргүүлтэй ажиллавал	25,0
3	Зүтгэгч автомашин	20,0
4	Өөрөө буулгагч автомашин	15,0
5	Тусгай зориулалтын автомашин	5,0
6	Эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээний зориулалтын автомашин	25,0
7	Цагдаагийн байгууллагын тусгай үүрэг чиглэлийн автомашин	20,0

32

Бүртгэлийн дугаар 625
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
 Хуулбар олгосон ажилтны гарын үсэг
 2019 оны 12 сарын 30-ний өдөр

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 сарын 30-ний өдрийн 30 дугаар тушаалын 5 дугаар хавсралт



**АВТОМАШИНЫ СЭЛБЭГ ХЭРЭГСЛИЙН ЭДЭЛГЭЭНИЙ
ДООД ХЯЗГААР НОРМ**

- 5.1. Аж ахуй нэгж, байгууллага, иргэд нь автомашины резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн нормыг үйлдвэрлэгчийн тогтоосон эдэлгээний нөөцийн доод хязгаарыг үндэс болгон өөрсдөө тогтоож мөрдөнө.
- 5.1.1. Резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн нормыг уур амьсгал, авто замын нөхцөлийг харгалзан тогтоосон ашиглалтын бүсээс хамааруулан резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг нормыг доорх хувиар хорогдуулан тооцож болно.

Бүсийн дугаар	Тухайн бүсэд багтах аймгууд	Эдэлгээний нөөцийн доод хязгаарыг хорогдуулах хувь
I бүс	Сэлэнгэ, Булган, Орхон, Дархан-Уул, Төв, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Дорнод, Хэнтий	-
II бүс	Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Хөвсгөл	10,0

- 5.1.2. Мод бэлтгэх карьерын нөхцөл нь ашиглалтын бүсийн ялгаанаас хамаарахгүйгээр хоёр бүсэд аль алинд нь ижил байх учир энэ нөхцөлд резин дугуйн эдэлгээний гүйлтийн нормын тооцоонд ашиглалтын бүсийн хорогдуулах хувийг хэрэглэхгүй.
- 5.1.3. Автомашины тээвэрлэлтийн нөхцөлийг харгалзан резин дугуйн эдэлгээний гүйлтийн нормыг доорх хувиар бууруулан хэрэглэж болно.

№	Автомашины тээвэрлэлтийн нөхцөл	Эдэлгээний гүйлтийн нормыг бууруулах хувь
1	Байнга нэг чиргүүлтэй ажилладаг ачааны автомашинд	15,0
2	Мод бэлтгэл, уул уурхайн карьерын нөхцөлд тогтмол ажилладаг ачааны автомашинд	30,0
3	Байнга 2 чиргүүлтэй буюу 10 тн-оос дээш даацтай, олон голт чиргүүл /трейллер/ чирдэг автомашинд	25,0
4	Бартаа саад ихтэй авто замын онцгой хүнд нөхцөлд ажилладаг цагдаагийн байгууллагын автомашинд	25,0

- 5.1.4. Зарим үйлдвэрлэгчийн резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын нормыг хүснэгт 5.3-т үзүүлэв.



Хүснэгт 5.3. РЕЗИН ДУГУЙН ЭДЭЛГЭЭНИЙ ГҮЙЛТИЙН ДООД ХЯЗГААР

№	Резин дугуйн төрөл, хэв маяг, хэмжээ загвар	Эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг /мян.км/											
		DUNLOP	MICHILEN	BRIDGESTONE	YOKOHAMA	TOYO	HANKOOK	КУМНО	NOKIAN	BARUM	BARNAUL	YAROSLAVI	KAMA
СУУДЛЫН АВТОМАШИН													
R12													
1	145/70												
2	145/80	35.0	35.0	35.0	35.0	32.0	32.0	32.0	30.0	30.0	30.0	30.0	30.0
3	145 SR (8PR) даац												
R13													
4	155/70												
5	155/80												
6	165/70												
7	165/80												
8	175/65												
9	175/70												
10	175/80												
11	185/65												
12	185/70												
13	195/60												
14	195/65												
15	205/60	45.0	45.0	45.0	45.0	42.0	42.0	42.0	42.0	42.0	41.0	41.0	40.0
R14													

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саяд Гөршгийн нарийн бичгийн дарга *С.Г.Г.*

625
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуульбар олгосон зүйлтийн баримт дүрс
2019 оны 12 сарын 30

Бүртгэлийн дугаар 625
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуульбар олгосон зүйлтийн баримт дүрс
2019 оны 12 сарын 30

АЧААНЫ АВТОМАШИН БОЛОН АВТОБУС													
145	265/70												
146	275/55												
147	275/60												
148	275/65												
149	275/70												
150	145/80 R12 (6PR, 8PR)	35.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	30.0	30.0
151	145/SR 12 (6PR, 8PR)	38.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	35.0	-	30.0
152	6.45 R13	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0
153	8.40 R15	60.0	60.0	60.0	55.0	55.0	55.0	55.0	55.0	55.0	50.0	50.0	50.0
154	8.40 R20	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0
155	9.00 R20	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0
156	10.00 R20	60.0	60.0	60.0	60.0	55.0	55.0	55.0	55.0	55.0	50.0	50.0	50.0
157	11.00 R20	60.0	60.0	60.0	60.0	55.0	55.0	55.0	55.0	55.0	50.0	50.0	50.0
158	12.00 R20	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0
159	14.00 R20	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0
160	12.00 R18	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0
161	13.00 R18	50.0	50.0	50.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	45.0	40.0	40.0	40.0
162	12.00 R22.5	70.0	70.0	70.0	65.0	65.0	65.0	65.0	65.0	65.0	60.0	60.0	60.0
163	335/80 R20	60.0	60.0	60.0	60.0	55.0	55.0	55.0	55.0	55.0	50.0	50.0	50.0

Бүртгэлийн дугаар ...
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
 хуулбар олгосон ажилтны гарын үсэг
 20 ... оны ... сарын ...-ний өдөр



Бүртгэлийн дугаар **625**
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
 хуулбар олгосон ажилтны гарын үсэг
 20 **09** /**12** сарын **30**-ний өдөр

МОНГОЛ УЛСЫН
 ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
 ЭХ ХУВЬ
 Санд Төрөлтийн Байгууллагын
 Даргач **619** /**30** сарын 30-ны өдөр

- 5.2. Аж ахуй нэгж, байгууллага, иргэд нь автомашины зай хураагуур буюу аккумуляторын эдэлгээний хугацааны нөөцийн доод хязгаарын нормыг үйлдвэрлэгчийн тогтоосон эдэлгээний нөөцийн доод хязгаарыг үндэс болгон өөрсдөө тогтоож мөрдөнө.
- 5.2.1. Автомашины зай хураагуур буюу аккумуляторын эдэлгээний хугацааны доод хязгаарын үндсэн нормыг автомашины тусгай төхөөрөмж нь хөдөлгүүр унтраасан үед зай хураагуураас тэжээл авч ажиллах зайлшгүй шаардлагатай /GPS, дохиолол, тог хувиргагч гэх мэт/ тусгай үүрэг чиглэлийн автомашинуудад төхөөрөмжийн тооноос хамааруулан зай хураагуурын эдэлгээний нормыг 50 хүртэл хувиар бууруулан тооцож болно.
- 5.2.2. Зарим үйлдвэрлэгчийн зай хураагуурын эдэлгээний хугацааны доод хязгаарыг хүснэгт 5.4-т үзүүлэв.

Хүснэгт 5.4. ЗАЙ ХУРААГУУРЫН ЭДЭЛГЭЭНИЙ ХУГАЦААНЫ ДООД ХЯЗГААР

№	Зай хураагуурын төрөл, ампер цаг	Үйлдвэрлэсэн улс	Эдэлгээний хугацааны доод хязгаар, /сараар/
1	Akuma-66 түүний төрлүүд	Чех	32
2	Grand-Plus, Duples-Норресег түүний төрлүүд	Герман	32
3	Declor-DE90R, 80D26R, 95D31R түүний төрлүүд	Солонгос	43
4	Yusimi түүний төрлүүд	Солонгос	36
5	Solite түүний төрлүүд	Солонгос	30
6	Panasonic түүний төрлүүд	Япон	36
7	HITACHI түүний төрлүүд	Япон	36
8	FIAMM түүний төрлүүд	Итали	42
9	DOUGLAS-675, TURBO PLUS-75, American түүний төрлүүд	АНУ	42
10	6CT түүний төрлүүд	ОХУ	24
11	ROCKET түүний төрлүүд	ОХУ	28
12	6Q түүний төрлүүд	Хятад	21
13	Loingjiang түүний төрлүүд	Хятад	18
14	ТОВО түүний төрлүүд	Хятад	18



Хүснэгт 5.5. Автомашины үндсэн агрегат, зангилаануудын эдэлгээний доод хязгаар

/МЯН.КМ/

Эд анги	Суудлын автомашин (Хөдөлгүүрийн эзэлхүүнээр см ³)		Автобус (багтаамж уртаар/				Ачааны автомашин (даацаар/				
	Бага эзэлхүүнтэй 1,8л хүртэл	Дунд эзэлхүүнтэй 1,8-3,5 л	Онцгой бага 5 м хүртэл	Бага багтаамжтай 6-7,5 м	Дунд багтаамжтай 8-9,5 м	Их багтаамжтай 10,5-12,0 м	Онцгой бага даацтай 0,3-1,0 тн хүртэл	Бага даацтай 1,0-3,0 тн хүртэл	Дунд даацтай 3,0-5,0 тн хүртэл	Их даацтай 5,0-8,0 тн хүртэл	Онцгой их даацтай 8,0 тн- дээш
1	Хөдөлгүүр, авцуулах холбоо										
1.1. Бензин											
- Блок, тахир гол	-	150	125	150	200	250	125	150	200	200	250
- Тэжээл форсунк	-	70	70	70	70	80	70	70	70	80	80
- Усны насос	-	120	80	80	100	120	80	100	120	120	120
- Тосны насос	-	150	70	70	80	200	70	80	100	150	200
- Динам, вакум насос	-	60	60	60	60	60	60	60	60	60	60
- Стартер	-	60	60	60	60	60	60	60	60	60	60
1.2. Дизель											
- Блок, тахир гол	125	150	125	150	200	-	125	150	200	150	200
- Карбюратор	60	60	60	80	80	-	60	60	80	80	80
- Инжектор цаагч	80	90	80	90	-	-	120	150	-	-	-
- Очлуур	30	50	30	50	50	-	30	30	50	50	50
- Динам	80	80	80	80	80	80	80	80	80	80	80
- Стартер	50	60	60	60	60	60	60	60	60	60	60
1.3. Авцуулах холбоо											
- Шахах зэрэнхий	125	150	125	125	150	150	125	125	150	150	150
- Хөтлөгдөгч зэрэнхий	60	80	60	80	80	100	60	60	80	100	100
2	Хурдны хайрцаг										
2.1. Механик											
- Их бие, таг арьс	125	150	125	150	200	250	125	150	200	200	250
- Араа голууд	80	80	80	80	100	120	90	100	120	200	200
2.2. Автомат											
- Их бие, таг арьс	150	200	-	-	200	250	-	-	-	-	-
- Араа голууд	100	100	-	-	100	150	-	-	-	-	-
3	Хөтлөгч ба урд тэнхлэг										
Урд хөтлөгч тэнхлэгийн арьс хөндлөвч	250	200	-	-	-	-	-	-	-	-	-

ЗАМ. ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажлалтны гарын үсэг
2019 оны 12 сарын 30 ний өдөр


ЗАМ. ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажлалтны гарын үсэг
20... оны ... сарын ... ний өдөр

МОНГОЛ УЛСЫН
ЗХ ХУВЬ
Салд Төрөөс мэдэгдсэн өмчлөлийн
дэргэтийн 390 дугаар тусламж

-	Хойд хөтлөгч тэнхлэг, ерөнхий дамжуулга, арьс, их бие	250	300	250	300	250	300	200	-	-
-	Деференциалын аяга, чагт	150	250	150	300	250	300	200	-	-
-	Хагас гол, дугуйн бул	60	80	80	200	150	300	150	-	-
-	Тоормозны хурд, диск тэлэгчүүд	60	80	60	60	60	60	80	-	-
-	Кардан дамжуулга	60	80	80	150	100	200	150	-	-
-	Пүрш, нум, амортизатор	60	70	60	80	100	200	100	-	-
4	ЖОЛООНЫ УДИРДЛАГА									
-	Жолооны гол	125	150	125	200	150	250	100	150	200
-	Хорхой араа ба хэдрэг	80	100	125	200	150	250	100	125	200
-	Жолооны хүчлүүр	80	150	80	200	150	200	150	200	250
-	Хөндлөн дагуу татуургууд	60	80	80	150	100	200	60	80	150
-	Өндгөн тулгуур бөмбөлгөн хуруу	80	120	80	150	100	200	80	100	150
5	АЧААНЫ АВТОМАШИНЫ КАБИН, СУУДЛЫН АВТОМАШИН, АВТОБУСНЫ КУЗОВ									
-	Чулуу, хрьс, хаялга	250	300	250	300	250	600	200	300	350
-	Тэвшний хөндлөвч гуя, шал	200	250	250	300	250	400	200	300	400
-	Багажны таг	250	300	-	-	-	-	150	200	250
-	Суурь шал, хөндөл	-	-	250	400	300	300	-	-	-
-	Арлын дагуу гуя	-	-	250	250	300	300	150	200	250
-										400

Тайлбар:

- Автомашины үндсэн агрегат, зангилаануудын эдэлгээний нөөцийн доод хязгаарын нормыг тухайн эд ангийг үйлдвэрлэсэн үйлдвэрлэгчийн тогтоосон эдэлгээний нөөцийг үндэс болгон аж ахуйн нэгж байгууллага өөрсдөө тогтоож мөрдөнө.
- Тухайн эд ангид тогтоосон эдэлгээний нөөц тодорхой бус үед хүснэгт 5.5-т заасан эдэлгээний нөөцийг баримжаа болгон аж ахуйн нэгж байгууллага өөрсдөө тогтоож мөрдөж болно.



АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН НОРМ

Танилцуулга

Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормыг “Дэд бүтцийн сайдын “Жишиг норм батлах тухай” 2004 оны 19 дүгээр тушаалаар батлан улсын хэмжээнд өнөөг хүртэл мөрдөж байна. Уг нормд 2003 оны байдлаар Монгол Улсад 10-аас дээш тоогоор орж ирсэн марк, загварын автомашинуудад шатахуун зарцуулалт, автомашины эдэлгээний нөөц, резин дугуй, зай хураагуур, агрегат зангилаануудын эдэлгээний нөөцийн доод хязгаарыг тогтоож өгсөн.

Энэхүү нормд орсон автомашинууд нь өнөөгийн байдлаар 15 ба түүнээс дээш жилийн насжилттай дийлэнх нь ашиглалтаас хасагдсан автомашинууд байгаа тул өнөөгийн автопаркийн бүтцэд тохирсон манай орны ашиглалтын нөхцөлийг тусгасан нормыг шинэчлэн боловсруулах шаардлагатай болсон.

Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормыг шинэчлэн боловсруулахад дараах зарчмыг баримталсан. Үүнд

- Автопаркийн бүтцийг 2018 оны байдлаар судалж автомашины ашиглалтын нормыг шинэчлэн тогтоох марк загваруудыг тогтоох
- Түүвэр судалгаагаар сонгогдсон марк загварын автомашины техникийн үзүүлэлтүүдийг үндэслэн шатахуун зарцуулалтын жишиг нормыг тогтооход шаардлагатай үйлдвэрлэгчийн болон гадны орны автомашины техникийн үзүүлэлтийг судлах.
- Автомашины ашиглалтын нормын тогтоосон өөрийн орны болон гадны эрдэмтдийн хийсэн судалгааны ажлуудыг үндэслэх.
- Автомашины шатахуун зарцуулалт, шатахуун зарцуулалтыг өсгөх нөхцөлүүд, хувь хэмжээг хянан, шинэчлэн тогтоохын тулд шатахуун зарцуулалтын туршилт, хэмжилтийн ажлуудыг тодорхой хугацаанд хийх.
- Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормыг шинэчлэн боловсруулахад шаардлагатай судалгаа, хэмжилт туршилтын ажлуудыг хийж жишиг нормын төслийг боловсруулах зэрэг болно.

Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормын төслийг дараах бүтэцтэй боловсруулсан. Үүнд:

1 дүгээр хавсралт: Автомашины шатахуун зарцуулалтын жишиг норм

Автопаркийн бүтцэд 2018 оны байдлаар Монгол Улсад 10-аас дээш тоогоор орж ирсэн 2007 оноос хойш үйлдвэрлэгдсэн 480 гаруй марк загварын автомашинуудын судалгааг хийж монгол орны ашиглалтын нөхцөлийг тусгасан автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг аналитик арга болон туршилт, хэмжилтийн аргын тусламжтайгаар шинэчлэн боловсруулсан. Уг хавсралтад багтсан автомашинуудыг орон нутгийн зам болон хөдөлгөөний эрчим ихтэй

Улаанбаатар хотын зам/хөдөлгөөний эрчмийг тооцсон/-д 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг хэмжээг тогтоож өгсөн.

2 дугаар хавсралт: Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд:

“Дэд бүтцийн сайдын “Жишиг норм батлах тухай” 19 дүгээр тушаалын 2-7 дугаар хавсралтуудыг нэгтгэн шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон хорогдуулах нөхцөлүүд болох хүйтний улирал, авто зам, ажил үйлчилгээ, авто замын онцгой хүнд нөхцөлүүдийн нэмэгдүүлэх болон хорогдуулах хувь хэмжээг судалгаа, туршилт, хэмжилтийн аргыг үндэслэн шинэчлэн тогтоосон.

Уг хавсралтад тусгасан гол өөрчлөлт нь бүх автомашинд тооцдог хүйтний улирлын нэмэгдлийн хугацаа хувь хэмжээг ялгавартайгаар шинэчлэн тогтоосон. Өөрөөр хэлбэл өнөөгийн автопаркийн бүтцэд ашиглагдаж буй инжектор, дизель, хосолмол /инжектор-цахилгаан/ хөдөлгүүр бүхий автомашинуудад хүйтний улирлын шатахуун зарцуулалтын бодит хэмжээг тогтоох судалгаа, туршилтын ажлын үр дүнг үндэслэн шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх хувь хэмжээг гадна хэмээс хамааруулан шинэчлэн тогтоосон. Өнөөгийн мөрдөж байгаа хүйтний улирлын хувь хэмжээ нь Улаанбаатар хотод 12 дугаар сард 5,5 хувь нэмэгдүүлж байгаа бол шинэчлэн тогтоосон нормоор 20 хувиар тогтоогдсон нь 100 км гүйлтэд 10 л зарцуулдаг автомашины хувьд 10,55 л байсныг, шинэчлэн тогтоосон нормоор 12,0 л шатахуун зарцуулахаар болж байгаа юм. Одоо мөрдөж байгаа 5,5 хувь нэмэгдлээр тооцоход хүйтний улиралд автомашины шатахуун зарцуулалт хүрдэггүй тул шатахуун зарцуулалтыг хүйтний улиралд шинэчлэн тогтоолгох явдал их байдаг бөгөөд хүйтний улирлын шатахуун зарцуулалтын бодит хэмжээг үндэслэн тогтоолгосон нормоор дулааны улирлын шатахуун зарцуулалтыг 5,5 хувийг хасан тооцоход дулааны улиралд олгох шатахууны хэмжээ бодит зарцуулалтаас хэт өндөр байдаг байсан.

Мөн Улаанбаатар хотын авто замын ачаалал болон автотээврийн хэрэгслийн тоо 2004 оныхоос эрс өөрчлөгдсөн тул хөдөлгөөний эрчмийн нэмэгдэл буюу Улаанбаатар хотын замд ажиллах автомашинуудын шатахуун зарцуулалтын нэмэгдлийг 5 хувь байсныг шатахуун зарцуулалтын судалгаа, туршилтын ажлын үр дүнг үндэслэн 25 хувиар шинэчлэн тогтоож өгсөн. Мөн Дэд бүтцийн сайдын 19 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтаар тогтоосон Нийслэл болон аймгийн төвүүдэд ажиллах автомашины шатахуун зарцуулалтын нэмэгдүүлэх болон хорогдуулах хувь хэмжээ буюу өндөршилийн нэмэгдлийг авто замын нөхцөлөөс хамааруулж шатахуун зарцуулалтыг нэмэгдүүлэх болон хорогдуулах нөхцөлд тооцдог, одоогийн ашиглаж буй автомашинуудын хөдөлгүүрт уг өндөршилийн нөлөөллийг хамгийн бага байхаар тооцон үйлдвэрлэж байгаа зэрэг нөхцөлийг үндэслэн уг өндөршилийн өөрчлөлтийг тусгасан хувь хэмжээг хассан болно. Харин технологийн тээвэр гүйцэтгэж буй автомашин, тусгай төхөөрөмж бүхий автомашин, автомашиныг хүйтний улиралд халаах зэрэг автомашины гүйлтээр шатахуун зарцуулалтыг тооцож олгох боломжгүй нөхцөлд 1 цагт зарцуулах

шатахууны хэмжээ буюу мото.цагийн шатахуун зарцуулалтыг уг нормд шинээр тусгаж өгсөн.

3 дугаар хавсралт: Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж жишээ.

Автомашины жишиг нормыг баримжаалан үндсэн норм тогтоох, шатахуун зарцуулалтын нэмэгдлүүдийг хэрхэн тооцох, автомашины ажилд олговол зохих шатахууны хэмжээг тооцох зэрэг аргачлал, заавар, зөвлөмжийг автомашины бүхий аж ахуйн нэгж, иргэд ашиглах боломжтой хэрэглэхэд энгийн, тодорхой ойлгомжтой байлгах зарчмыг баримтлан шинэчлэн боловсруулсан.

4 дүгээр хавсралт Автомашины эдэлгээний нөөцийн доод хязгаар, гүйлтийн норм

Дэд бүтцийн сайдын 19 дүгээр тушаалаар батлагдсан Автомашины эдэлгээний нөөцийн жишиг норм нь үйлдвэрлэгчээс тогтоосон эдэлгээний нөөцийг марк загвараар жагсаалтаар батлуулсан норм юм. Иймд өнөөгийн нөхцөлд үйлдвэрлэгчид эдэлгээний нөөцийн доод хязгаарыг гүйлтээр, хугацаагаар тогтоож байгаа бөгөөд үйлдвэрлэгчээс өгсөн эдэлгээний нөөцийн доод хязгаарыг автомашины марк, загвар бүрээр, жагсаалтаар тогтоох шаардлагагүй гэж үзэн үйлдвэрлэгчээс тогтоосон эдэлгээний нөөцийг шууд мөрдөх заалтыг нэмж тусгасан. Харин манай орны ашиглалтын нөхцөл, ажил үйлчилгээний онцлогоос хамаарах нөхцөлүүдийг хэвээр үлдээн зарим нэмэлтийг оруулсан.

5 дугаар хавсралт: Автомашины сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаарын норм

Дэд бүтцийн сайдын 19 дүгээр тушаалаар батлагдсан 9-11 дүгээр хавсралтад тусгагдсан автомашины агрегат зангилаа, резин дугуй, зай хураагуурын эдэлгээний нөөцийг нэгтгэн 5 дугаар хавсралтад тусгасан. Уг тушаалаар баталсан ашиглалтын нөхцөлийг тусгасан заалтуудыг хэвээр үлдээж зарим нэмэлт өөрчлөлтүүдийг тусгаж өгсөн бөгөөд үйлдвэрлэгчээс тогтоосон сэлбэг хэрэгслийн эдэлгээний нөөцийг мөрдөх тухай заалтыг нэмж тусгасан.

Гэрээт ажлын хүрээнд шинэчлэн боловсруулсан Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормын төслийг холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн албан бичгээр болон ЗТХЯ-ны цахим хуудсанд байршуулан санал авч төсөлд тусган Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормын шинэчлэн боловсруулаад байна.

“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ”

Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаал болон Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 224 тушаалаар батлагдсан Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормыг шинэчлэн тогтоосон төсөлд хийсэн нөлөөллийн шинжилгээ

2019.12.24.

1. Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар:

2018 оны тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллээс харахад Монгол Улсад нийт 970818 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас 537657 нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна. Нийт тээврийн хэрэгслийн 65 хувь буюу 631421 нь суудлын автомашин эзэлж байна. Ачааны автомашин 190406, автобус 6501, тусгай зориулалтын автомашин 21467, зүтгүүр 21534, механизм 12561, чиргүүл 31043, мотоцикл 55913 тус тус бүртгэгдсэн байна.

Улсын хэмжээнд 2018 онд 551,5 мянган тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байна. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт тээврийн хэрэгслийн 82 хувийг иргэд, 14,6 хувийг компани, аж ахуйн нэгж, байгууллагууд, 1,9 хувийг төрийн болон орон нутгийн өмч, 1 хувийг төрийн бус байгууллага, 0,4 хувийг гадаадын иргэд, 0,1 хувийг дипломат болон олон улсын байгууллагууд эзэмшиж байна.




Зураг1. Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгсэл /2017 он/



Зураг 2. Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгсэл /хосолсон, хийн, цахилгаан хөдөлгүүртэй/

Сүүлийн жилүүдэд автомашины хэрэглээ улам ихэсч байгаатай холбогдуулан импортоор орж ирж буй тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсээр байна. Монгол Улсад 2015 онд 37086 тээврийн хэрэгсэл, 2016 онд 37735, 2017 онд 48871 тээврийн

хэрэгсэл орж ирсэн бол 2018 онд энэ үзүүлэлт огцом өсч, импортоор оруулж ирсэн тээврийн хэрэгслийн тоо 100 мянгад хүрсэн байна.¹



Зураг 3. Монгол Улсын тээврийн хэрэгслийн судалгаа
/импорт 2015-2018/

Хүн амд ноогдох автомашины эзлэх түвшин өсч, дэлхийн олон орны автомашин үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн төрөл бүрийн марк, загварын тээврийн хэрэгслүүд Монгол Улсад бүртгэгдэж байна. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаал болон Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 224 тушаалаар батлагдсан автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормыг шинэчлэн батлуулах шаардлага тулгарч байна. Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалаар батлагдсан автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормыг тогтоохдоо тухайн үеийн 600 гаруй автотээврийн хэрэгслийг хамруулсан.

Шинэчлэн боловсруулсан төсөлд автотээврийн хэрэгслийг сонгохдоо Монгол Улсад бүртгэгдсэн нийт тээврийн хэрэгслээс 2007 оноос хойш үйлдвэрлэгдсэн араваас дээш тоогоор орж ирсэн бүх марк загварыг сонгон, жишиг нормыг туршилтын үр дүнд тогтоосон.

Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг суудлын автомашин, ачааны автомашин, автобус гэсэн ангиллаар автомашины марк загвар, хөдөлгүүрийн багтаамж, шатахууны төрлөөр болон орон нутгийн замд, хөдөлгөөний эрчим ихтэй замд дулаан, хүйтний улирлаар тус бүрт шатахуун зарцуулалтын жишиг нормыг тогтоосон.

2. Тушаалын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар:

Уг тушаалаар автомашины шатахуун зарцуулалтын жишиг норм, шатахуун зарцуулалтын жишиг нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүд, автомашин, түүний үндсэн агрегат, зангилаанууд, резин дугуй, зай хураагуурын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм, түүнийг нэмэгдүүлэх болон хорогдуулах нөхцлүүдийг тусгаж өгснөөр эдгээр нөхцлүүдийг өөрсдийн ажил, үйлчилгээний онцлогт нийцүүлэн автотээврийн байгууллага, аж ахуйн нэгж, автотээврийн хэрэгсэл бүхий иргэдэд зөвлөмж болгох зорилготой.

¹Зам тээврийн хөгжлийн яамны мэдээллийн сан, 2018

Шинэчлэн боловсруулсан тушаалын төсөл нь дараах ерөнхий бүтэцтэй. Үүнд:

□ “Жишиг норм батлах тухай” тушаалын төсөл нь 3 үндсэн заалттай байна. Нэгдүгээр заалтаар тушаалын 5 хавсралтыг баталсан бол хоёрдугаар заалтаар автотээврийн хэрэгслийн ашиглалтын тогтоосон нормыг өөрсдийн ажил, үйлчилгээний онцлогт нийцүүлэн автотээврийн байгууллага, аж ахуйн нэгж, автотээврийн хэрэгсэл бүхий иргэдэд зөвлөмж болгосон. Гурав дахь заалтаар энэхүү тушаал батлагдахтай холбогдуулан одоогийн мөрдөгдөж буй Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаал болон Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 224 тушаалын тус тус хүчингүй болгохоор заасан байна.

□ тушаалын нэгдүгээр хавсралтаар “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг;

□ тушаалын хоёрдугаар хавсралтаар “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүд”-ийг;

□ тушаалын гуравдугаар хавсралтаар “Автомашинны шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г;

□ тушаалын дөрөвдүгээр хавсралтаар “Автомашинны эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн норм”-ыг;

□ тушаалын тавдугаар хавсралтаар “Автомашинны сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаарын норм”-ыг тус тус батлахаар тусгагдсан.

Тушаалын нэмэлт, өөрчлөлтийн төсөлд:

- Энэхүү тушаалын төсөл нь автотээврийн байгууллага, аж ахуйн нэгж, автотээврийн хэрэгсэл бүхий иргэдэд зөвлөмж болохоор боловсруулагдсан.

- Одоогийн мөрдөгдөж буй тушаал нь нийт 11 хавсралттай байгаа бөгөөд шинэчлэн боловсруулсан төсөлд илүү ойлгомжтой байлгах үүднээс хавсралтуудыг нэгтгэн, хялбаршуулан 5 үндсэн хавсралттай болгосон.

- Илүү олон тооны тээврийн хэрэгслийг хамруулж шатахуун зарцуулалтын судалгааг хийсэн, тээврийн хэрэгслийн марк загвар, хөдөлгүүрийн багтаамж, шатахууны төрлөөр сонгон орон нутгийн зам болон Улаанбаатар хотод /хөдөлгөөний эрчим ихтэй замд/ дулаан, хүйтний улирлаар шатахуун зарцуулалтыг тогтоож өгснөөрөө хэрэглэхэд хялбар, тооцоог хялбаршуулсан, автомашинны шатахуун зарцуулалтын нормыг бодит зарцуулалтад нийцүүлэх зорилгоор туршилт, судалгаан дээр үндэслэн боловсруулсан.

- Автомашинны шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар нь одоогийн мөрдөгдөж буй тушаалд онол, томъёо их байсныг шинэчлэн боловсруулсан төсөлд зөвлөмж хэлбэрээр томъёо тус бүрийн тайлбарыг холбогдох жишээ болгон дээр нарийвчлан тайлбарлаж, “Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ” болгон боловсруулсан.

- Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг суудлын автомашин, ачааны автомашин, автобус гэсэн ангиллаар автомашинны марк загвар, хөдөлгүүрийн багтаамжаар тодорхойлноос гадна шинэчлэн боловсруулсан төсөлд шатахууны төрлөөр болон орон нутгийн замд, хөдөлгөөний эрчим ихтэй замд дулаан ба хүйтний улирлаар тус бүрт шатахуун зарцуулалтын жишиг нормыг шинээр тогтоосон.

- Одоогийн мөрдөгдөж буй тушаалд тусгагдаагүй “Автомашинны хөдөлгүүрийн асаалтын нэг цагт зарцуулах шатахууны норм”-ыг тогтоосон. Энэ талаар маш олон

гомдол, өргөдлийг хувь хүн, албан байгууллагуудаас ирүүлдэг бөгөөд энэхүү асуудал тушаал батлагдсанаар шийдвэрлэгдэх болно.

- Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормыг шинэчлэн тогтоохдоо холбогдох судалгаа, туршилтыг тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төв, тэдгээр ажиллаж буй инженерүүдийн тусламжтайгаар Зөвлөх багийнхан 2015 оны өвлөөс 2018 оныг хүртэл хийж гүйцэтгэсэн. Туршилтыг хотын болон хотын гаднах авто замуудад хийсэн.

- Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, Зөвлөхүүдийн болон уулзалт, хэлэлцүүлгийн үеэр гарсан саналуудыг тусгасан.

- Зам тээврийн хөгжлийн яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаас гарсан саналуудыг тусгасан.

3. Тушаалын төсөл батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлсон талаар:

Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормыг шинэчлэн боловсруулах ажлын даалгаварт тусгагдсаны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 07/2442 дугаар албан бичгээр, Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-аас 2018 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 2/1766 дугаар албан бичгээр, Зам, тээврийн хөгжлийн төвөөс 2018 оны 08 сарын 01-ний өдрийн 1/400 дугаар албан бичгээр, Засгийн газрын автобаазаас 2018 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 1/153 дугаар албан бичгээр, Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газраас 2018 оны 09 дүгээр сарын 18-ны дб/06-719 дугаар албан бичгээр тус тус саналыг хүлээн авсан. Мөн Зэвсэгт хүчний 089 дүгээр анги, Засгийн газрын автобааз Хяналтын инженер Н.Балжинням, Нийслэлийн Түр захиргааны баазаас инженер Т.Бат-Эрдэнэ, Ховд аймгийн Автотээврийн төвийн инженер Д.Чинзориг нар нь цахимаар холбогдох саналуудыг ирүүлсэн байна.

Мөн ажлын даалгаварт тусгагдсаны дагуу холбогдох хэлэлцүүлгийг 2016 оны 04 дүгээр сард, 09 дүгээр сард, 2017 оны 05 дугаар сард тус яаман дээр, 2017 оны 10 дугаар сард Автотээврийн Үндэсний төв ТӨҮГ дээр тус тус зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Зам, тээврийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар, Зам, тээврийн хөгжлийн төв, Засгийн газрын автобааз, Зэвсэгт хүчний 089 дүгээр анги, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ, "Монголын автомашины дистрибьюторүүдийн ассоциаци" ТББ, Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөллүүд оролцсон.

Шинэчлэн боловсруулсан нормын төсөлд санал авахаар Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу тус яамны www.mrtd.gov.mn сайтад 2016 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байршуулсан.

Зам, тээврийн салбарын шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар шинэчлэн боловсруулсан нормыг хэлэлцүүлэн, холбогдох шийдвэрийг гаргуулан, холбогдох саналуудыг төсөлд эцэслэн тусгасан.

Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 207 дугаар тушаалаар шинэчлэн боловсруулсан нормд редакци, шүүмж хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг удирдамжийн хамтаар батлуулсан. Уг тушаалаар батлагдсан редакцийн багийн хийсэн дүгнэлтийн дагуу уг нормыг дахин хянаж, редакцийн багаас өгсөн саналуудыг тусгасан.

Шинэчлэн тогтоосон норм нь зөвлөмж бүхий бичиг баримт тул автотээврийн байгууллага, аж ахуйн нэгжүүд болон автотээврийн хэрэгсэл бүхий иргэдэд хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөхгүй, нэмэлт ачаалал үүсэхгүй.

4. Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авилга гарах нөхцөл бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх талаар:

Тушаалд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь:

- зөвлөмж болгон хэрэглэнэ;
- хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд хориг саад учруулсан, аливаа хүнд суртал, авилга үүсэх нөхцөл бүрдүүлсэн зохицуулалт агуулаагүй;
- хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй, жендерийн эрх тэгш байдлыг хөндөөгүй;
- дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөөнд нөлөө үзүүлэхгүй, үнийн хөөрөгдөл бий болгохгүй;
- аж ахуйн нэгжид, түүний дотор зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжүүдэд бэрхшээл, хүндрэл үүсгэхгүй, тэдгээрийн үйл ажиллагааг зогсоохгүй;
- эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд ямар нэгэн саад хориг тогтоогоогүй.

5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх талаар:

Шинэчлэн боловсруулсан төсөлд тусгагдсан харилцаа нь Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаал болон Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 224 тушаалаар зохицуулагддаг.

6. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүү эдийн засгийн тогтолцооны талаар:

Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхэд шинээр ямар нэгэн байгууллага байгуулагдаж захиргааны шинэ чиг үүрэг бий болохгүй, байгууллага бүрд хүний нөөцийг нэмэгдүүлэх шаардлагагүй, санхүү, эдийн засгийн нэмэлт зардлууд шаардагдахгүй.

АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ГАНТУЛГА

Хянасан:
ТЗУГ-ын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

Г.Очхүү

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН НОРМЫН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁОГ

№	Ирүүлсэн санал	Санал тусгасан эсэх, тайлбар
1	<p>Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 07/2442 тоот албан бичиг</p> <p>Дэд бүтцийн сайдын 2004 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 19 дугаартай тушаалаар баталсан “Жишиг норм”-д заасан үйлдвэрлэгчээс тогтоосон автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг шинээр боловсруулж буй “жишиг норм”-ын төсөлд бууруулах мөн автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг хүйтний улиралд нэмэгдүүлэх хувь хэмжээ /+20%/ болгож эрс нэмэгдүүлж тооцсон үндэслэлийг тайлбарлах.</p>	<p>Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалаар батлагдсан Автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормд хүйтний улирлын нэмэгдлийг бүсээс хамааруулан автомашины шатахуун зарцуулалтыг 5-10% өсгөдөг байсныг төслөөр 20-25%-иар нэмэгдүүлэхээр шинэчлэн оруулсан. Энэхүү шатахуун зарцуулалтын нэмэгдлийг хүйтний улиралд хийсэн хэмжилт туршилтын үр дүнгээр тогтоосон.</p>
2	<p>Тус улсад ашиглагдаж буй нийт автотээврийн хэрэгслийн 650 мянга гаруй буюу 85-аас дээш хувь нь үйлдвэрлэгдсэнээс хойш 10-аас дээш жил ашиглагдсан эдэлгээний баталгаат гүйлтийн нөөц багатай, шатахуун зарцуулалтын хэмжээг тогтоох шаардлагатай тээврийн хэрэгслүүд байдаг тул тэдгээр нийцүүлэн автомашиныг ашиглагдсан жилээс хамааруулан 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг нормыг тогтоох.</p>	<p>Автомашины ашиглалт нь тухайн тээврийн хэрэгслийн хадгалалт, техникийн үйлчилгээ, засварыг тухай бүр хийсэн байдал, ажил, үйлчилгээний онцлог, явсан гүйлт, улмаар тухайн тээврийн хэрэгслийн жолоочийн ур чадвар зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг тул автомашины насжилт ижил байвч техникийн байдал харилцан адилгүй байх тул ашиглагдсан жилээс хамааруулан шатахуун зарцуулалтыг тогтоох боломжгүй юм. Автомашины ашиглалтын явцад техникийн байдлыг бүрэн, хэвийн ажиллагаатай байлгахад анхаарах бөгөөд шатахуун зарцуулалтын нормыг автомашины техникийн байдал хэвийн, шатахуун зарцуулалтад нөлөөлөх ямар нэгэн эвдрэл, гэмтэлгүй автомашинд тогтоон мөрддөг. Иймд насжилт өндөртэй автомашины жишиг нормыг үндсэн норм болгон мөрдөхдөө тодорхой хугацаанд туршиж үзэх,</p>

		<p>хэмжилт хийх аргаар бодит зарцуулалттай харьцуулан мөрдөх тайлбар, зааврыг 1 дүгээр хавсралтад тусгаж өгсөн.</p> <p>Даевоо маркийн их багтаамжийн автобусны шатахуун зарцуулалтын жишиг нормыг төсөлд тусгасан. Нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглагдаж буй автобус нь Нийтийн тээврийн үйлчилгээ. Ангилал, Ерөнхий шаардлага MNS 5012:2012 үндэсний стандартад заасан хугацаанд нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглана. Автомашины үйлдвэрлэгч, автомашины төрлөөр эдэлгээний нөөцийн доод хязгаарыг 2 дугаар хавсралтад тусгасан.</p>
<p>3</p>	<p>Даевоо маркийн их багтаамжийн автобусны эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг нормыг тогтоох, Монгол Улсад ашиглагдаж байгаа бусад холбогдох стандартын ишлэл, найруулгатай нийцүүлэн уялдуулсан эсэхийг нягтлаж, дээрх саналыг тусган бусад холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас санал авах нь зүйтэй байна.</p> <p>"Жишиг норм"-ын төслийг зарчмын хувьд дэмжиж байна.</p>	<p>II Автотээврийн үндэсний төв ТӨҮГ, 2018 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 2/1766 тоот албан бичиг</p>
<p>1</p>	<p>Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг тооцохдоо тухайн автомашины үйлдвэрлэгчээс тогтоосон шатахууны экологийн ангиллыг тооцдог байх.</p>	<p>Автомашины шатахуун зарцуулалтын жишиг норм нь автомашинд техникийн тодорхойлолтоор заасан шатахуун зарцуулалтын норм, манай улсын ашиглалтын нөхцөлөөс хамааран өөрчлөлт байгаа эсэхийг тогтоон, хувь хэмжээ, өөрчлөлтийг техникийн тодорхойлолтоор заасан нормтой харьцуулах, өөрчлөлтийг тусган заавар, зөвлөмжийн хамт нийтийн хүртээл болгох зорилготой. Ашиглалтын нөхцөлд өнөөгийн замын нөхцөл, байгаль, цаг уурын нөлөөлөл, ашиглагдаж байгаа шатахууны чанар зэргээс хамааран автомашины шатахууны бодит зарцуулалттай нийцүүлэх зарчмыг баримталдаг. Өөрөөр хэлбэл одоо ашиглагдаж байгаа автомашинд манай улсад импортоор орж ирж байгаа шатахуунаар 100 км гүйлтэд хэдэн л зарцуулж байгааг тогтоож өгснөөр иргэд аж ахуйн нэгж байгууллага шатахууныхаа тооцоо, санхүүд ашиглах юм.</p>
<p>2</p>	<p>Автомашины үндсэн, агрегат, зангилаануудын эдэлгээний нөөцийг тооцохдоо эд ангийн гарал үүсэл, чанар аюулгүй байдлыг харгалзан үздэг байх.</p>	<p>Автомашины эд, анги, сэлбэг хэрэгсэл нь чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан гарал үүсэл тодорхой байх шаардлагатай. Иймд гарал үүсэл тодорхой бус сэлбэг хэрэгсэлд уг норм хамаарахгүй тайлбарыг 3 дугаар хавсралтад тусгаж өгсөн.</p>

III	Зам, тээврийн хөгжлийн төв, 2018 оны 08 сарын 01-ний өдрийн 1/400 тоот албан бичиг	
1	"Автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормын төсөл" нэршлийн доор удиртгал, тайлбар оруулах	Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалыг Автотээврийн хэрэгслийн ашиглалтын норм гэсэн товхимол болгон хэвлүүлэхэд удиртгал, тайлбарыг бичиж оруулсан. Шинэчилсэн ашиглалтын нормын төсөлд удиртгал бичих шаардлаггүй, тайлбарыг тухай бүр оруулж өгсөн.
2	1-р хавсралтын 1 "Автомашини 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-д үзүүлсэн автотээврийн хэрэгслийн жишиг норм тооцож гаргасан жишээ оруулах 1-р хавсралтын 3 "Автомашини шатахуун зарцуулалтын нормыг тооцох аргачлал зөвлөмж"-т Toyota gas'is суудлын автомашины жишиг нормыг хяналтын нормоор нь тооцсон боловч дээрх жишиг нормд үзүүлсэн нормтой зөрж байна. Хэрэв нэмэгдлийг тооцсон бол түүнийг тодорхой харуулах.	Жишээ тайлбарыг цогцоор 1-р хавсралтын заавар, зөвлөмж хэсэгт оруулж өгсөн. Дахин хянан үзсэн.
3	"Автомашини шатахуун зарцуулалтын нормыг тооцох аргачлал зөвлөмж"-г ойлгомжтой товч байдлаар үзүүлэх, 6 шатлалтай тооцож байна.	Одоо мөрдөж байгаа ашиглалтын нормын зааврын нүсэр их тооцоолол томъёог энгийн хэлбэрт шилжүүлэн, норм тогтоох дарааллын дагуу, зөвлөмж, тайлбарыг энгийн болгох тал дээр анхаарсан. /1 дүгээр хавсралтын Автомашини шатахуун зарцуулалтын норм тогтоох заавар, зөвлөмж хэсэг/
4	1-р хавсралтын 2.3 "Үндсэн нормыг нэмэгдүүлэх тусгай нөхцлүүд"-т Автотээврийн хэрэгслийн чиргүүлтэй (ачаатай болон ачаагүй) байх нөхцөлд шатахуун зарцуулалтын нормыг нэмэгдүүлэх хэмжээг	Саналыг тусгасан.
5	Цахилгаан болон хийн түлш (газ)хэрэглэдэг автотээврийн хэрэгслийн зарцуулалтын нормыг тооцож оруулах	Нормд 10-аас дээш тоогоор орж ирсэн автомашины шатахууны норм буюу бензин, дизель түлшээр ажилладаг автомашинууд зонхилж байгаа. Цахилгаан хөдөлгүүрийн хувьд шатахуун хэрэглэдэггүй тул шатахууны нормд тусгаагүй болно. Хийн түлшний хувьд тухайн түлшээр ажиллаж байгаа автомашинууд монгол орны ашиглалтын

	<p>Хүн амын нягтаршил болон хөдөлгөөний эрчмээс хамааруулан ангилж (1 саяас дээш -25%, 250 мянгаас 1 сая хүртэлх-15%, 100-250 мянга -10% гэх мэт) шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх хувь хэмжээг тооцох (Зөвхөн Улаанбаатар хотод тооцсон байна.)</p>	<p>нөхцөлд ямар өөрчлөлт гарч байгааг тусгайлан тодорхой хугацаагаар дагнан судалгаа явуулах шаардлагатай юм.</p> <p>Улаанбаатар хотын авто замын сүлжээнд түгжрэл саатал ихээр үүссдэг учир түгжрэл,саатлын нөлөөгөөр автомашины шатахуун зарцуулалт хэдэн хувиар өсч байгааг бодитоогоор тогтоох шаардлагатай бөгөөд судалгаа туршилтаар тогтоосон хувь хэмжээг хөдөлгөөний эрчимийн нэмэгдэл хэмээн нэрлэж нормд тусгадаг. Өнөөгийн байдлаар Улаанбаатар хотын авто замын ачааллыг тооцсон энэхүү шатахуун зарцуулалтын хувь хэмжээг зайлшгүй дахин хянах шаардлага тулгарсан. Энхүү нэмэгдэл нь одоогийн авто замын сүлжээ, түүн дээр зорчиж байгаа тээврийн хэрэгслийн тооноос шууд хамааралтай бөгөөд хүн амын тооноос хамааруулан тооцдоггүй. Өөрөөр хэлбэл авто замын сүлжээ, түүн дээр зорчиж байгаа тээврийн хэрэгслийн тоо ч нийслэл, аймагт харилцан адилгүй юм. Мөн нийслэл Улаанбаатар хотоос өөр түгжрэл саатал ихээр үүссэн хот, аймаг одоогоор байхгүй болно.</p>
6	<p>Шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх тусгай нөхцөлүүдээр дараах ажил, үйлчилгээний чиглэлээр ашиглагдах автотээврийн хэрэгслийн нормыг тооцож нэмж оруулах Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Авто замын хөдөлгөөнт эргүүл (Авто замын тухай хуулийн 11.1.13, 24.5 дахь заалт, Авто зам, замын байгууламж ашиглалтын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор хөдөлгөөнт эргүүл ажиллуулах) • Онцгой байдлын газрын автотээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтын норм, нэмэгдлийг тооцож оруулах 	<p>Авто замын хөдөлгөөнт эргүүлийн автомашины чиг үүрэг нь яаралтай тусламж үзүүлэх зорилгоор байнга автомашины хурд хүчийг нэмэгдүүлэх, ажил үйлчилгээний онцлог нөхцлөөр нэмэгдэл төхөөрөмжүүдийг суурилуулах, авто замын онцгой хүнд нөхцөл буюу замгүй газраар тээвэрлэлт хийх, тусгай хурд, тээвэрлэлтийн горим зэрэг нөхцөлүүдийг байнга хангаж ажиллахгүй буюу ажил үйлчилгээний онцлогоос хамааруулан автомашины шатахуун зарцуулалтыг нэмэгдүүлэх нөхцөлд хамаарахгүй гэж үзэж байна.</p> <p>Тухайлбал, Цагдаагийн тусгай чиг үүргийн автомашин буюу Улаанбаатар хотын хөдөлгөөнт эргүүлийн 24 цагаар ажилладаг автомашинуудыг дээрх нормд оруулж өгсөн хэдий ч хотын хөдөлгөөний эрчимийн нэмэгдлийг хасаад 5%-иар нэмэгдүүлсэн. Уг ажил үйлчилгээний онцлог нь гэр</p>
7		

		<p>хороолын бартаа нугачаа, огцом өгсүүр бүхий ердийн хөрсөн зам, гэр хорооллын доторх олон гудамж шүлжин бага хурдаар явах зэрэг нөхцөлийг тооцсон хувь хэмжээ юм.</p>									
8	<p>Автотээврийн хэрэгслийн ашигласан хугацаа болон явсан гүйлтээс хамааруулж ангилж, нормын нэмэгдлийг тооцож оруулах.</p> <table border="1" data-bbox="411 1242 639 1979"> <thead> <tr> <th>Ашиглалт, жил</th> <th>Гүйлт, км</th> <th>Нэмэгдэл, %</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>5-8</td> <td>100 мян.км-ээс Дээш</td> <td>5</td> </tr> <tr> <td>8-12</td> <td>150 мян.км-ээс Дээш</td> <td>8</td> </tr> </tbody> </table>	Ашиглалт, жил	Гүйлт, км	Нэмэгдэл, %	5-8	100 мян.км-ээс Дээш	5	8-12	150 мян.км-ээс Дээш	8	<p>Автомашин ашиглалт нь тухайн тээврийн хэрэгслийн хадгалалт, техникийн үйлчилгээ, засварыг тухай бүр хийсэн байдал, ажил, үйлчилгээний онцлог, явсан гүйлт, улмаар тухайн тээврийн хэрэгслийн жолоочийн ур чадвар зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг тул автомашины насжилт ижил байвч техникийн байдал харилцан адилгүй байх тул ашиглагдсан жилээс хамааруулан шатахуун зарцуулалтыг тогтоох боломжгүй юм. Автомашины ашиглалтын явцад техникийн байдлыг бүрэн, хэвийн ажиллагаатай байлгахад анхаарах бөгөөд шатахуун зарцуулалтын нормыг автомашины техникийн байдал хэвийн, шатахуун зарцуулалтад нөлөөлөх ямар нэгэн эвдрэл, гэмтэлгүй автомашинд тогтоон мөрддөг. Иймд жишиг нормыг үндсэн норм болгон мөрдөхдөө тодорхой хугацаанд туршиж үзэх, хэмжилт хийх аргаар бодит зарцуулалттай харьцуулан мөрдөх тайлбар, зааврыг 1 дүгээр хавсралтад тусгаж өгсөн.</p>
Ашиглалт, жил	Гүйлт, км	Нэмэгдэл, %									
5-8	100 мян.км-ээс Дээш	5									
8-12	150 мян.км-ээс Дээш	8									
9	<p>1-р хавсралтын 2.3 “Үндсэн нормыг нэмэгдүүлэх тусгай нөхцөлүүд”-т Байгаль цаг уурын хүнд нөхцөлд (цасан шуурга, үер ус гэх мэт) ажиллах автотээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх хувь хэмжээг тооцох оруулах</p>	<p>Жишиг нормын нэмэгдлийг тооцоход тухайн улирлын буюу жилийн турш судалгаа, туршилт хийж тухайн улирлын нэмэгдэл олгох хувь хэмжээг тогтоодог. Хүйтний улирлын нэмэгдлийг тооцоход гадна температур, авто замын нөхцөл /халтиргаа, гулгаа/, хадгалалт, зэрэг бодит нөхцөл байдалд автомашин ямар ачаалал гаргаж болохыг туршилт, судалгаагаар тогтоосон болно. Үер ус, цасан шуурга зэрэг байгалийн үзэгдэл нь тухайн улирлын онцлог, автозамын нөхцөлд тооцогдсон гэж үзэж болно.</p>									
10	<p>1-р хавсралтын 2,3 “Үндсэн нормыг нэмэгдүүлэх тусгай нөхцөлүүд”-т Жолооны сургалтын машины сургалтын маневарлах талбайд ажиллах нөхцөлд нормыг хувь хэмжээгээр тооцож нэмж оруулах.(Зөвхөн шулуун замд</p>	<p>Жолооны сургалтын автомашины нэмэгдлийг тооцоход сургалтын хугацаанд жолооны дадлага туршлага хийх үйл ажиллагааг хамруулсан болно. Өөрөөр хэлбэл, жолооны сургалтад дадлага хийх үйлдэл болон автомашин</p>									

	ажиллах үед нормыг тооцсон байна.)	жолоодож сураагүй хүн автомашиныг жолоодоход автомашины хурд хүчийг тохируулж чадаж байгаа эсэх зэрэг нөхцөл байдал тооцогдсон.
11	Дулааны болон хүйтний улиралд агааржуулагч ажиллуулахад зарцуулах шатахууны нэмэгдлийг хөдөлгөөнд оролцох болон зогсоолын талбайд гэж ангилан тооцож оруулах (1 дүгээр хавсралтын 2,5-д Зөвхөн автотээврийн хэрэгслээс цахилгаан эх үүсвэр авах, хөдөлгүүрийг халаах зориулалтаар ажиллуулахад зарцуулах шатахууны нэмэгдлийг тооцсон байна.)	Туршилт хэмжилтийн аргаар тогтоосон хүйтний улирлын нэмэгдэлд халаагуурын нэмэгдлийг оруулан тооцсон болно. Мото цагийн нэмэгдлийг улирлаас хамаарахгүй автомашин зогсож байхдаа хөдөлгүүр ажиллахад шаардагдах шатахууны хэмжээг тусгасан болно.
12	Аюулгүй байдлын үүднээс автотээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг унтраахгүй ажиллах нөхцөлд зарцуулагдах шатахууны нормыг тооцож оруулах. Жишээлбэл: (Газрын тосны үйлдвэр болон агуулах, хөргөх боломжгүй ачааг тээвэрлэх, банк бусад объектод)	Гүйлтээс гадна зогсох тохиолдолд хөдөлгүүр унтраахгүй горим шаардах тээвэрлэлтийг ажлын зураг авалт хийж тухайн тээвэрлэлтийг гүйцэтгэхэд хэдэн мото.цаг шаардлагтай байгааг тогтоон гүйлтэд олгох шатахуун зарцуулалт дээр мото.цагт олгох шатахууныг нэмэж олгоно.(хавсралт 1-д мото.цагт олгох шатахууны хэмжээг тусгасан) Өөрөөр хэлбэл ачааны онцлогоос хамааран тээвэрлэлтийн горим өөр байх тул тухайн ачааг тээвэрлэхэд зарцуулах мото.цаг харилцан адилгүй тул ажлын зураг авалт хийж хугацааг нормчлох шаардлагатай байдаг.
13	Автомашины гэдгийг автотээврийн хэрэгслийн гэж өөрчлөх	Автотээврийн хэрэгсэл гэдэг ойлголтод бүх төрлийн автомашин, чиргүүл, мотоцикл . . . гэсэн ойлголт багтаж байгаа тул автомашин гэснийг хэвээр үлдээв.
14	Дүрмийн болон найруулгын алдааг залруулах. Өгүүлбэрт нэг дор тодорхойлолт олон дахин давтагдахгүй байхаар найруулж сайжруулах	Саналыг тусгав.
15	Хүснэгт томъёог дугаарлах	Саналыг тусгав.
16	Тайлбарыг ойлгомжтой товчхон болгох	Саналыг тусгав
17	Хуудас дугаарлах	Саналыг тусгав
18	1-р хавсралтын 1 "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ын хүснэгтийн 2 дугаар баганын эхний мөрөнд "Автомашины марк, загвар" гэдгийг "Автотээврийн хэрэгслийн марк, загвар"гэх	Автомашин гэдгийг хэвээр үлдээв. Тайлбар ижил.

19	15-р хуудас “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүд” гэдгийг “Үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүд” гэх	Тодорхой байх шаардлагатай гэж үзэн хэвээр үлдээв
20	18-р хуудас 2,3-ын “Ажил үйлчилгээний онцлог, автозамын онцгой хүнд нөхцлийг харгалзан автомашины шатахуун зарцуулалтын” гэдгийг хасах	Хэвээр үлдээв
21	18-р хуудас 2,3-ын Ажил үйлчилгээний онцлог, автозамын онцгой хүнд нөхцлийг харгалзан автомашины шатахуун зарцуулалтын гэдгийг хасах.	-
22	2,3-ын хүснэгтийн 7-д “мал амьтан” гэж нэмж оруулах.	-
23	18-р хуудас Тайлбарыг “1-р хавсралтын 1-д үзүүлсэн автотээврийн хэрэгслийн жишиг нормыг Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний эрчмийн шатахуун зарцуулалтын нэмэгдлийг тооцсон болно” гэж өөрчлөх	Санал тусгав
24	Автомашины гэдгийг Автотээврийн хэрэгслийг гэх	Тайлбар ижил
23	Редакцийн чанартай саналууд	Саналыг тусгав
IV	Засгийн газрын автобааз 2018 оны 09 дүгээр сарын 14-ний 1/153 тоот албан бичгээр ирүүлсэн санал	
1	1-р хавсралт “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм” хүснэгт дэх шатахуун зарцуулалтын жишиг норм манай авто баазад ашиглагддаг автомашиныг харахад бага байна. Автомашины жишиг нормыг тогтооходоо үйлдвэрлэгчийн тогтоосон хяналтын норм болон ашиглалтын нөхцөлийн нэмэгдэл өөрчлөлтийг нэмэж тооцдог. Хавсралт 1-ээс үзэхэд үйлдвэрлэгчийн тогтоосон хяналтын норм дээр хүйтний улирлын нэмэгдэл, хөдөө орон нутгийн нэмэгдэл, хотын түгжрэл нягтралын нэмэгдлүүдийг тооцжээ. Үйлдвэрлэгчийн тогтоосон хяналтын нормыг ихэнх автомашинд далайн төвшнөөс дээш өндөршлийн /800-2000м/т 10, зун кондишн, өвөл дулааны парны нэмэгдэл 6%ь тооцох, мөн бүх автомашинд Монгол орны	Үйлдвэрлэгчийн тогтоосон хяналтын норм дээр монгол орны ашиглалтын нөхцлийг тусгасан коэффициентээр нэмэгдүүлэн жишиг нормыг тооцсон. Мөн нэмэлт өөрчлөлт оруулж байгаа нэмэгдлүүд нь шатахууны бодит зарцуулалтад тулгуурлан өнөөгийн зах зээл дээр борлуулагдаж буй шатахуунаар сорил, туршилт, судалгааны ажлыг хийж тооцоолж болох нэмэгдлүүдийг бүрэн тусгасан болно.

	<p>ашиглалтын нөхцөлийг /бензин чанар, авто замын чанар/ харгалзан 10% өсгөх саналтай байна.</p>	
2	<p>Гибрид автомашины /Toyota prius/өвлийн улиралд салони дулааныг бензин хөдөлгүүр хангадаг учир зүтгүүрийн батерей цэнэгтэй байсан ч хүйтний улиралд дотоод шаталтын хөдөлгүүр ажиллаж улмаар шатахуун зарцуулалтын нормд хүрдэг. Өөрөөр хэлбэл Prius 20, 4 цилиндртэй, 1800 cc хөдөлгүүр хүйтний улиралд 9-10 л байх нь бодит юм.</p>	<p>Шатахуун зарцуулалтын туршилтад хосолмол хөдөлгүүр бүхий Prius автомашины судалгааг багтаан хүйтний улирлын нэмэгдлийг тооцоолсон болно.</p>
3	<p>Авто замын нөхцөлөөс хамааруулж, шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах хэсэгт өөрчлөлт ороогүй байна. Манай улсын ихэнх аймаг авто замтай холбогдож замын нөхцөл сайжирсан. Орчин үеийн автомашины хүч дамжуулах анги сайжран дугуйн дээр очих максимум эргэлдэх хүчийг хөдөлгүүрийн маш бага эргэлтэд дээр л гаргадаг болсон. Иймд хуучны Газ, Зил автомашины үед гаргасан бүсчлэлийн нэмэгдлийг бүгдийг өөрчлөх цаг нь болсон.</p>	<p>Авто замын нөхцөлөөс хамааруулан шатахуун зарцуулалтын нэмэгдлийг тооцох хэсэгт зөвхөн ердийн хөрсөн зам хамаарч байгаа бөгөөд хатуу хучилттай автозамын сүлжээ тухайн орон нутагт бий болсон тохиолдолд уг нэмэгдлийг тооцохгүй болох тайлбарыг шинээр тусгасан. Тухайлбал Архангай аймгийн Тариат сум хүртэл хатуу хучилттай авто замаар холбогдсон хэдий ч Тариат сум нь хатуу хучилттай авто замын сүлжээ бий болоогүй тул уг суманд ердийн хөрсөн замд ажиллаж байгаа автомашины нэмэгдэл хэвээр байх юм.</p>
4	<p>Автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг хүйтний улиралд нэмэгдүүлэх хэсэгт бодит байдалтай ойртсон өөрчлөлт орсон байна. Гэхдээ 2,3-р бүсийг 1-р бүстэй адил нэмэгдэл олгох, хугацааг хүйтний үе, хэт хүйтрэлтийн үе гэж хуваах нь зөв болов уу. Жишээ нь Улаанбаатар 10 дугаар сарын 15-аас 12 дугаар сарын 19-ний хооронд 10%, 12 дугаар сарын 21-ээс 02 дугаар сарын 19 хүртэл 20%, 02 дугаар сарын 20-оос 04 дүгээр сарын 10 хооронд 10% нэмэх нь зүйтэй болов уу.</p>	<p>Саналын дагуу хэмжилт, туршилтын дүн, цаг уур орчны шинжилгээний судалгааг үндэслэн тусгав.</p>
5	<p>Ажил үйлчилгээний онцлог, авто замын онцгой хүнд нөхцөлийг харгалзан автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх хэсэгт автомашины насжилтын нэмэгдлийг оруулах саналтай байна. Өөрөөр хэлбэл 120,000 километрээс дээш гүйлттэй суудлын автомашинд 5%, 180,000 км-ээс дээш</p>	<p>Автомашины насжилтаас хамаарууж шатахууны нэмэгдэл олгохгүй, тайлбар ижил.</p>

	5%, 250,000 км-ээс дээш 10% нэмэх гэж оруулах саналтай байна.	
6	Автомашин үндсэн агрегат зангилаануудын эдэлгээний нөөцийн жишиг нормд 3,5 литрээс дээш хөдөлгүүрийн эзэлхүүнтэй автомашинууд байхгүй байна. Эдгээр үндсэн, агрегат зангилаануудын эдэлгээний нөөцийн жишиг нормыг зөвхөн автомашинтайгаа шинээр ирсэн солигдоогүй эд ангид тооцох, солигдсон сэлбэгийг бууруулж шийдвэрлэх нь зүйтэй.	Манай улсын автопаркад 10-аас дээш тоогоор орж ирсэн, 2007 оноос хойш үйлдвэрлэгдсэн автомашинууд жишиг нормд тусгагдсан. Мөн шинээр орж ирэх автомашинуудын нормыг иргэд, аж ахуйн нэгж байгууллага өөрсдөө тогтоон мөрдөх заавар, зөвлөмжийг нэмж тусгасан. Автомашин сэлбэг хэрэгслийн хувьд үйлдвэрлэгчийн тогтоосон чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан сэлбэгийн гүйлтийн нормыг тусгасан.
7	Резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг нормын хэсэгт өөрчлөлт оруулаагүй байна. Монгол Улсын зах зээлд нийлүүлэгдэж байгаа бүх брендийн шинэ дугуй Хятад дахь үйлдвэрээс нь нийлүүлэгддэг. Иймээс манайд нийлүүлэгддэг суудлын болон жип автомашины дугуй 50,000-80,000 км зам явна гэдэг бодит байдалд нийцэхгүй байгаа юм. Олон жилийн туршлагад харахад бүх брендийн дугуй 45,000 км зам, яваад хэзэ элэгдэж 2 мм-ээс бага болдог.	Резин дугуйн хувьд үйлдвэрлэгчээс тогтоосон гүйлтийн нормыг мөрдөнө. Резин дугуйн жишиг норм нь үйлдвэрлэгчээс тогтоосон нормыг шууд тавьсан буюу ямар нэгэн ашиглалтын хорогдуулах болон нэмэгдүүлэх коэффициентыг ашиглаагүй болно.
V	Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар 2018 оны 09 дүгээр сарын 18-ны дб 06-719 тоот албан бичиг	
1	Автомашин үйлдвэрлэгчийн шатахуун зарцуулалтын тогтоосон стандарт норм нь Монголын нөхцөлд тохирдоггүйг анхаарах	Үйлдвэрлэгчийн тогтоосон хяналтын нормыг монгол орны ашиглалтын нөхцөлд шилжүүлэн нэмэгдүүлж тооцсон байгаа.
2	Хүйтний улирлын нэмэгдэл /+5.5%/-ыг +15% болгож өөрчлөх	Хүйтний улирлын нэмэгдлийг 20 хүртэл хувь болгон нэмэгдүүлсэн.
3	Замын хөдөлгөөний эрчим ихтэй Улаанбаатар хотод ажиллах техник хэрэгслийг шатахуун зарцуулалтын үндсэн зарим бүлэг байдгийг 20% болгож өлсөх. Уг үрж 2004 онд батлагдсан жишиг нормоос хойш өнөөг хүртэл /2018 он/ машины тоо замын ачаалал хэд дахин нэмэгдсэн.	Ашиглалтын нормын төсөлд хөдөлгөөний эрчимийн нэмэгдлийг туршилт хэмжилтийн аргаар 20 хувиар нэмэгдүүлэхээр төсөлд тусгагдсан байгаа.
4	Зуны улиралд эйр кондишн их асаадаг автомашины хөдөлгүүрийн эргэлтэд ачаалал өгч араа хүндрүүлэх	Зуны улиралд эйр кондишн ажиллуулах тохиолдолд гадна хэмээс хамааруулан өдөрт ажиллах дундаж хугацааг

	шалтгаан болдог. Иймд үндсэн нормыг нэмэх юмуу кондейшний нэмэгдэл тооцдог болгох.	тооцон үндсэн нормын 5 хувиар тооцон олгохыг төсөлд тусгасан байгаа.
5,6	Нийслэл болон аймгийн төвд ажилладаг автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх Улаанбаатар хотод 0,0% байдаг бол Зуун мод хотод +5,0% байдаг. Цаг агаарын нөхцөл, агаарын температурын хэмжээг бүсүүдэд харьцуулалт хийж, нийслэл болон аймгийн төвд ажилласан авто машины нормыг нэмэгдүүлэх хувьтай уялдуулж гаргаж бүсийн нэмэгдэлдээ өөрчлөлт оруулах саналтай байна.	Энэхүү нэмэгдэл нь авто замын нэмэгдэлд тооцогдсон байдаг тул өндөршлийн буюу нийслэл болон аймгийн төвд ажилласан нэмэгдлийг төслөөс хассан. Мөн сүүлийн жилүүдэд үйлдвэрлэгдэж байгаа автомашин хөдөлгүүр, хүч дамжуулах анги нь өндөршлийн нөлөөллийг арилгасан тул тооцох шаардлаггүй гэж үзсэн.
7	Ажил үйлчилгээний онцлогийн нэмэгдлийг нэг бол тусад нь гаргаж ирж 19-р тоот тушаалын 5-р хавсралтад нэмэж оруулах саналтай байна.	Шатахуун зарцуулалтын нэмэгдлийн 1 хэлбэр тул шаардлаггүй болно.
8	Манай байгууллагын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийн жишиг нормыг нэмэж өгнө үү /автомашини шатахуун зарцуулалт, автомашины жагсаалт/	Хянаж, саналыг тусгав
VI	Зэвсэгт хүчний 089 дүгээр анги	
1	Тус анги нь батлан хамгаалахын яам болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Зэвсэгт хүчний жанжин штабын удирдлагын бүрэлдэхүүнд албан ажлын дуудлагын автомашинуудаар үйлчилдэг юм. Сүүлийн жилүүдэд нөхөн хангагдсан тээврийн хэрэгслүүдийн 100 километрийн гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын тогтоосон нормгүй байгаагаас ашиглалтад хүндрэл учирч байна. Иймд хавсралтад заагдсан тээврийн хэрэгслүүдийн шатахуун зарцуулалтын жишиг нормыг тогтоох, холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг талаар тодорхой мэдээлэл өгч бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү /Автомашинуудын талаарх мэдээллийг хасралтаар ирүүлсэн./	Хавсралтаар ирүүлсэн автомашинуудын мэдээллийг төсөлд тусгасан эсэхийг хянан үзэв.
VII	Засгийн газрын автобааз Хяналтын инженер Н.Балжинням, цахимаар ирүүлсэн, санал	
	2004 оны 19 дүгээр тушаал дээр хүйтний улиралд	Автомашини 1 цаг асаалтай байлгах шатахуун

	автомашин 1 цаг асаалттай байлгахад зарцуулах шатахуун зарцуулалтын нормыг тусгаагүй байдаг. Энэ төсөл дээр хамруулмаар байна.	зарцуулалтыг төслийн 1 дүгээр хавсралтад 1 мото цагийн шатахуун зарцуулалт гэж тусгасан байгаа.																																										
1	<p align="center">НТЗАБааз Т.Бат-Эрдэнийн цахимаар ирүүлсэн санал</p> <p>Автомашинны пүрш, амартизатор, перда диск, ган диск зэрэг сэлбэгийн эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг нормийг дахин багасгах саналтай байна.</p>	Зах зээл дээр худалдаалагдаж байгаа сэлбэг хэрэгсэл нь гарал үүсэл тодорхойгүй, автомашины баталгаат сэлбэг хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангахгүй, жишиг нормоос эдэлгээний хугацаа доогуур байгаа тул эдгээр сэлбэг хэрэгсэлд жишиг нормыг мөрдөхгүй тухай тайлбар оруулав. Мөн тухайн сэлбэг хэрэгслийн хувьд ашиглалтад судалгаа хийж нормыг өөрсдөө тогтоож мөрдөх боломжтой юм.																																										
2	<p>100 километр гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг нормийг доорхи маркийн автомашинуудын хувьд нэмэгдүүлэх саналтай байна. Үүнд:</p> <table border="1" data-bbox="749 1084 1382 1991"> <thead> <tr> <th rowspan="2">№</th> <th rowspan="2">Автомашинны марк</th> <th rowspan="2">Хөдөлгүүрийн багтаамж, см.куб</th> <th colspan="2">Замын хөдөлгөөний эрчим ихтэй замд /Улаанбаатар хотод/</th> </tr> <tr> <th>Дулааны улиралд</th> <th>Хүйтний улиралд</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Accent</td> <td>1399</td> <td>11.0</td> <td>11.5</td> </tr> <tr> <td>2</td> <td>Azera</td> <td>2188</td> <td>16.8</td> <td>17.6</td> </tr> <tr> <td>3</td> <td>Land Cruiser 200</td> <td>4200</td> <td>21.0</td> <td>22.0</td> </tr> <tr> <td>4</td> <td>Sonata 7</td> <td>1999</td> <td>14.5</td> <td>15.2</td> </tr> <tr> <td>5</td> <td>Starex</td> <td>2351</td> <td>15.4</td> <td>16.2</td> </tr> <tr> <td>6</td> <td>Nissan Urvan</td> <td>2488</td> <td>18.5</td> <td>19.4</td> </tr> <tr> <td>7</td> <td>Teana</td> <td>2249</td> <td>18.5</td> <td>19.4</td> </tr> </tbody> </table>	№	Автомашинны марк	Хөдөлгүүрийн багтаамж, см.куб	Замын хөдөлгөөний эрчим ихтэй замд /Улаанбаатар хотод/		Дулааны улиралд	Хүйтний улиралд	1	Accent	1399	11.0	11.5	2	Azera	2188	16.8	17.6	3	Land Cruiser 200	4200	21.0	22.0	4	Sonata 7	1999	14.5	15.2	5	Starex	2351	15.4	16.2	6	Nissan Urvan	2488	18.5	19.4	7	Teana	2249	18.5	19.4	Саналд ирүүлсэн автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг хянаж үзэв.
№	Автомашинны марк				Хөдөлгүүрийн багтаамж, см.куб	Замын хөдөлгөөний эрчим ихтэй замд /Улаанбаатар хотод/																																						
		Дулааны улиралд	Хүйтний улиралд																																									
1	Accent	1399	11.0	11.5																																								
2	Azera	2188	16.8	17.6																																								
3	Land Cruiser 200	4200	21.0	22.0																																								
4	Sonata 7	1999	14.5	15.2																																								
5	Starex	2351	15.4	16.2																																								
6	Nissan Urvan	2488	18.5	19.4																																								
7	Teana	2249	18.5	19.4																																								

	<p>chinzoigids@gmail.com Д.Чинзориг Ховд аймгийн Автотээврийн төв</p> <p>3 дугаар хавсралтын 2 дахь хэсэгт “Резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг норм”-д нэмэлтээр “Резин дугуйн ашиглалт, хадгалалтын зөвшөөрөгдөх хугацааг нормчилж өгье”. Учир нь резин дугуй үйлдвэрлэснээс эхлэн физик, химийн үйлчлэлд орж хуучирч шинж чанараа алддаг. Ихэнхи үйлдвэрлэгчид энэхүү хугацааг 10 жилээр тогтоосон байдаг. ОХУ 5 жилээр тогтоосон байна.</p> <p>Одоогийн байдлаар манай улсад импортоор орж ирдэг резин дугуй нь тухайн газартаа 8-10 жил ашигласан эсвэл хадгалагдаж байсан дугуй худаалагдаж байгаа нь хэрэглэгчийн эрх ашиг, замын хөдөлгөөний аюулгүй байдал, орчны эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангахгүй байна. Иймд резин дугуйн ашиглалтын болон хадгалалтын хугацааг нормчилон тогтоох нь зүйтэй юм.</p> <p>Резин дугуйн ашиглалт, хадгалалт нь үйлдвэрлэгчээс тогтоосон нөхцөл, горимыг ханган хадгалах шаардлагатай байдаг. Дугуйг худалдаалж буй газар, ашиглалтын хугацаанд хадгалах горим, нөхцөлийг хангасан байдлаас эдэлгээний хугацааг харилцан адилгүй байх тул нормчло шаардлаггүй гэж үзсэн. Энэхүү санлыг харгалзан ашиглагдаж байсан сэлбэг эд ангийн эдэлгээний үлдсэн хугацааг тогтоох, резин дугуйн хээний гүний хэмжээ үндэсний стандартын шаардлага хангахгүй тохиолдолд ашиглалтаас хасах тайлбарыг нэмэж тусгав.</p>
--	---

АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗАР

МУ-ын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаал болон ЗТБХБС-ын 2011 оны 224 дүгээр тушаалаар батлагдсан автотээврийн хэрэгслийн ашиглалтын нормыг шинэчлэн боловсруулсан хувилбартай харьцуулсан судалгаа

№	МУ-ын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаал	Шинэчлэн боловсруулсан хувилбар /Зам тээврийн хөгжлийн сайдын тушаалын төсөл/	Тайлбар
Сайдын тушаалын бүтцийн хувьд дараах байдлаар өөрчлөлтүүд хийгдсэн. Үүнд:			
1	Хавсралт 1 "Автомашини 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"	Хавсралт 1: "Автомашини 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"	
2	Хавсралт 2. Автомашини 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг автомашины ашиглалтын бүс (авто замын нөхцөл)-ээс хамааруулж нэмэгдүүлсэн болон бууруулсан хувь хэмжээ	Хавсралт 2: Автомашини 100 км гүйлтэд зарцуулалах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүд	МУ-ын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалаар батлагдсан жишиг нормын 2-6 дугаар хавсралтыг /шатахуун зарцуулалтын нэмэгдлүүд нэгтгэн, шинэчлэн боловсруулсан төсөлд 2 дугаар хавсралт "Автомашини 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүд" гэж тусгасан.
3	Хавсралт 3: Нийслэл болон аймгийн төвд ажилласан автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах хувь хэмжээ	Хавсралт 2: Автомашини 100 км гүйлтэд зарцуулалах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүд	
4	Хавсралт 4: Автомашини шатахуун зарцуулалтын үндсэн нормыг хүйтний улиралд нэмэгдүүлэх хувь, хэмжээ, мөрдөх хугацаа	Хавсралт 2: Автомашини 100 км гүйлтэд зарцуулалах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүд	
5	Хавсралт 5: Ажил үйлчилгээний онцлог, авто замын онцгой хүнд нөхцлийг харгалзан автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх тусгай нөхцлүүд	Хавсралт 2: Автомашини 100 км гүйлтэд зарцуулалах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцлүүд	
6	Хавсралт 6: Автомашини 100 тн/км тээврийн ажлын болон өөрөө буулгагч автомашины ачаагаа буулгахад зарцуулах шатахууны норм	Хавсралт 3: Автомашини шатахуун зарцуулалтын нормыг тооцох зөвлөмж, жишээ	
4	Хавсралт 7: Автомашини шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар	Хавсралт 4: Автомашин, сэлбэг хэрэгслийн жишиг норм	МУ-ын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалаар батлагдсан жишиг нормын 8-11 дүгээр хавсралтыг нэгтгэн, шинэчлэн боловсруулсан төсөлд 4 дүгээр хавсралт "Автомашин,
5	Хавсралт 8: "Автомашини эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм"		
6	Хавсралт 9: "Автомашини резин дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг норм"		
6	Хавсралт 10: "Автомашини зай хураагуурын эдэлгээний хугацааны доод хязгаарын жишиг норм"		

7	Хавсралт 11: "Автомашин үндсэн агрегат, зангилаануудын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм"		сэлбэг хэрэгслийн жишиг норм" гэж оруулсан.
8	3ТБХБС-ын 2011 оны 224 дүгээр тушаалын хавсралт; Цагдаагийн байгууллагын тусгай үүрэг, чиглэлийн автомашины ашиглалтын онцлогийг харгалзан тооцсон Цагдаагийн байгууллагын тусгай үүрэг чиглэлийн автомашинуудын ашиглалтын нэмэгдэл тооцох тухай	Хавсралт 2,4-т тусгагдсан.	Хавсралт 2, 4-т тусгагдсан.
Сайдын тушаалын хавсралтуудад агуулгын хувьд дараах нэмэлт, өөрчлөлтүүд хийгдсэн. Үүнд:			
1	Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг суудлын автомашин, жил, ачааны автомашин, автобус (том), автобус (бэсрэг) гэсэн ангиллаар үйлдвэрлэгчээс тогтоосон шатахуун зарцуулалтын нормыг үндэслэн нийт 620 марк, загварын автомашинд жишиг нормыг тогтоосон.	Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг суудлын автомашин, ачааны автомашин, автобус гэсэн ангиллаар автомашины марк загвар, хөдөлгөөний бэртэмж, шатахуун төрлөөр болон орон нутгийн замд, хөдөлгөөний эрчим ихтэй замд дулаан, хүйтний улирлаар тус бүрт шатахуун зарцуулалтын жишиг нормыг тогтоосон. Тээврийн хэрэгслийг сонгохдоо Монгол Улсад бүртгэгдсэн нийт тээврийн хэрэгслээс 2007 оноос хойш үйлдвэрлэгдсэн 10-аас дээш тоогоор орж ирсэн бүх марк загварыг сонгон, жишиг нормыг тогтоосон.	Илүү олон тооны тээврийн хэрэгслийг хамруулж шатахуун зарцуулалтын судалгааг хийсэн, тээврийн хэрэгслийн марк загвар, хөдөлгөөрийн багтаамж, шатахууны төрлөөр сонгон орон нутгийн зам болон Улаанбаатар хотод /хөдөлгөөний эрчим ихтэй замд/ дулаан, хүйтний улирлаар шатахуун зарцуулалтыг тогтоож өгснөөрөө хэрэглэхэд хялбар, тооцоог хялбаршуулсан, автомашины шатахуун зарцуулалтын нормыг бодит зарцуулалтад нийцүүлэх зорилгоор туршилт, судалгаан дээр үндэслэн боловсруулсан.
2	АВТОМАШИНЫ 100 КМ ГҮЙЛТЭД ЗАРЦУУЛАХ ШАТАХУУН ЗАРЦУУЛАЛТЫН ҮНДСЭН НОРМЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОН БУУРУУЛАХ НӨХЦЛҮҮД		
2.1	Автозамын нөхцөлөөс хамрааруулж шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах хувь хэмжээ		
-	Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг автомашины ашиглалтын бүс (авто замын нөхцөл)-ээс хамрааруулж нэмэгдүүлэх болон бууруулах хувийг тогтоосон. Автомашин ашиглалтын бүсийг I, II, III, IV ба V гэсэн 5 бүсэд хуваасан.	Авто замын нөхцлөөс хамрааруулж шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх ба бууруулах хувь хэмжээг тогтоосон. Автомашин ашиглалтын бүсийг I, II, III, IV ба V гэсэн 5 бүсэд хуваасан.	Бүсийн хувьд өөрчлөлт ороогүй.

	<p>Автомашинны ашиглалтын I бүсэд Архангай (3 сум), Өвөрхангай (2 сум), Баянхонгор (5 сум), Хөвсгөл (10 сум), Завхан (18 сум), Говь-Алтай (2 сум), Ховд (7 сум), Баян-Өлгий (9 сум), Увс (2 сум) аймгийн нутаг дэвсгэр хамрагдсан байна. I бүсийн шатахуун зарцуулалтын нэмэгдүүлэх хувь /+15/ байна.</p>	<p>Автомашинны ашиглалтын I бүсэд Архангай (3 сум), Өвөрхангай (2 сум), Баянхонгор (5 сум), Хөвсгөл (10 сум), Завхан (18 сум), Говь-Алтай (2 сум +1), Ховд (7 сум), Баян-Өлгий (9 сум), Увс (2 сум) аймгийн нутаг дэвсгэр хамрагдсан байна. Говь-Алтай аймгийн Бугат сум нэмэгдсэн. I бүсийн шатахуун зарцуулалтын нэмэгдүүлэх хувь 15 байна.</p>	<p>Шатахуун зарцуулалтын нэмэгдлийн хувь хэмжээнд өөрчлөлт ороогүй. Говь-Алтайн Бугат сумыг нэмж тусгасан. Бугат сумын хувьд өндөршлийн бүсэд хамаарагдахаас гадна авто замын байдал бартаа, саад (хад, асга) ихтэй, автомашин бага хурдаар ажилладаг тул I бүсэд нэмж оруулсан.</p>
	<p>Автомашинны ашиглалтын II бүсэд Говь-Алтай (15 сум), Завхан (5 сум), Ховд (4 сум), Баян-Өлгий (3 сум), Увс (12 сум), Төв (5 сум), Архангай (4 сум -1) аймгийн нутаг дэвсгэр хамрагдсан байна. Архангай аймгийн Их тамир сум хасагдсан. II бүсийн шатахуун зарцуулалтын нэмэгдүүлэх хувь /+10/ байна.</p>	<p>Автомашинны ашиглалтын II бүсэд Говь-Алтай (15 сум), Завхан (5 сум), Ховд (4 сум), Баян-Өлгий (3 сум), Увс (12 сум), Төв (5 сум), Архангай (4 сум -1) аймгийн нутаг дэвсгэр хамрагдсан байна. Архангай аймгийн Их тамир сум хасагдсан. II бүсийн шатахуун зарцуулалтын нэмэгдүүлэх хувь 10 байна.</p>	<p>Шатахуун зарцуулалтын нэмэгдлийн хувь хэмжээнд өөрчлөлт ороогүй Архангай аймгийн Их тамир сумын авто замын нөхцлөөс хамааруулах шатахуун зарцуулалтын хувь хэмжээ нь III бүсэд хамаарагдах боломжтой байсан.</p>
	<p>Автомашинны ашиглалтын III бүсэд Өмнөговь (6 сум), Баянхонгор (4 сум), Өвөрхангай (5 сум), Архангай (10 сум), Хэнтий (3 сум), Увс (5 сум), Булганы бүх сумд, Сэлэнгийн бүх сумдын нутаг дэвсгэр хамрагдсан байна. III бүсийн шатахуун зарцуулалтын нэмэгдүүлэх хувь /+5/ байна.</p>	<p>Автомашинны ашиглалтын III бүсэд Өмнөговь (6 сум), Баянхонгор (4 сум), Өвөрхангай (5 сум), Архангай (10 сум +1), Хэнтий (3 сум), Увс (5 сум), Ховд (5 сум), Булганы бүх сумд, Сэлэнгийн бүх сумдын нутаг дэвсгэр хамрагдсан байна. Архангай аймгийн Их тамир сум нэмэгдсэн. III бүсийн шатахуун зарцуулалтын нэмэгдүүлэх хувь /+5/ байна.</p>	<p>Архангай аймагт хийгдсэн туршилт судалгааны үндсэн дээр тус аймгийн Их тамир сумыг III бүсэд хамруулсан. Өөр нэмэлт өөрчлөлт ороогүй.</p>
	<p>Автомашинны ашиглалтын IV бүсэд Дорнодын бүх сум, Сүхбаатарын бүх сумдын нутаг дэвсгэр байна. IV бүсийн шатахуун зарцуулалтын бууруулах хувь /- 5/ байна.</p>	<p>Автомашинны ашиглалтын IV бүсэд Дорнодын бүх сум, Сүхбаатарын бүх сумдын нутаг дэвсгэр хамрагдсан байна. IV бүсийн шатахуун зарцуулалтын бууруулах хувь /- 5/ байна.</p>	<p>Нэмэлт өөрчлөлт ороогүй.</p>
	<p>I-IV бүсэд хамрагдаагүй аймаг, сумд шатахуун зарцуулалтын үндсэн нормыг мөрдөнө.</p>	<p>I-IV бүсэд хамрагдаагүй аймаг, сумд болон I-III бүсэд хамаарагдах аймаг, сумд хатуу хучилттай автозамын сүлжээтэй болсон үед шатахуун зарцуулалтын үндсэн нормыг мөрдөнө.</p>	<p>"I-III бүсэд хамаарагдах аймаг, сумд хатуу хучилттай автозамын сүлжээтэй болсон үед шатахуун зарцуулалтын үндсэн нормыг мөрдөнө" гэж нэмсэн. Авто замын нөхцлөөс хамааруулсан нэмэгдлийг ердийн хөрсөн замын онцлогыг харгалзсан тул хатуу хучилттай авто замын сүлжээтэй болсон тохиолдолд уг нэмэгдлийг тооцох шаардлагагүй болно.</p>

	<p>Нийслэл болон аймгийн төвд ажилласан автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах хувь хэмжээг тогтоосон.</p>	<p>Хасагдсан.</p>	<p>Авто замын нөхцлийн нормыг тогтооходоо тухайн орон нутгийн байршил, өндөршил, авто замын онцлогыг харгалзан тооцсон тул өндөршлийн нэмэгдлийн тусгайлан тооцох шаардлагагүй гэж үзсэн. Мөн сүүлийн үеийн автомашины хөдөлгүүр нь өндөршлийн нөлөөллөөс хамаарах шатахуун зарцуулалт маш бага болсон.</p>
<p>2.2</p>	<p>Автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг хүйтний улиралд нэмэгдүүлэх хувь хэмжээ, мөрдөх хугацаа</p>	<p>Автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг хүйтний улиралд нэмэгдүүлэх хувь хэмжээ, мөрдөх хугацааг тогтоосон. Хүйтний бүсийн ангиллыг I, II, III гэж тогтоосон байна. IV бүсийг II бүсэд хамруулсан.</p>	<p>Одоогийн мөрдөгдөж буй тушаалд Улаанбаатар хотыг бусад аймгаас ялгаж тодруулах байдлаар IV бүс гэж тусгасан байсныг II бүсэд шилжүүлсэн. I-III дугаар бүсийг хамгийн их хүйтэрдэг аймгаг сумдыг хамруулсан бол III дугаар бүсэд говийн бүсийн аймгууд буюу харьцангуй бага хүйтэрдэг аймаг сумдыг хамруулан, 3 бүсэд хүйтний нэмэгдэл олгох хугацааг ялгаатай тогтоосноос гадна шатахууны нэмэгдлийг гадна хэмийн өөрчлөлтөөс хамааруулан ялгавартай тогтоож өгсөн болно.</p>
<p>-</p>	<p>Хүйтний улирлын I бүсэд Завхан (8 сум), Хөвсгөл (8 сум) аймгийн нутаг дэвсгэрийг хамруулсан байна. Хүйтний улирлын нэмэгдлийг:</p> <ul style="list-style-type: none"> ▪ 10 дугаар сарын 10-наас 12 дугаар сарын 20-ныг хүртэл /+5/ хувиар; ▪ 12 дугаар сарын 21-нээс 2 дугаар сарын 15-ныг хүртэл /+10/ хувиар; ▪ 2 дугаар сарын 16-наас 4 дүгээр сарын 16-ныг хүртэл /+5/ хувиар тогтоосон байна. 	<p>Хүйтний улирлын I бүсэд Завхан (8 сум+4), Хөвсгөл (8 сум+2), Увс (13 сум) аймгийн нутаг дэвсгэрийг хамруулсан байна. Хүйтний улирлын нэмэгдлийг:</p> <ul style="list-style-type: none"> ▪ 10 дугаар сарын 10-наас 11 дүгээр сарын 10-ны хүртэл /+10/ хувиар; ▪ 11 дүгээр сарын 15-наас 2 дугаар сарын 15-ныг хүртэл /+25/ хувиар; ▪ 2 дугаар сарын 16-наас 4 дүгээр сарын 16-ныг хүртэл /+10/ хувиар тогтоосон байна. 	<p>Завхан аймгийн Яруу, Тосонцэнгэл, Отгон, Тэс сумд, Хөвсгөл аймгийн Арбулаг, Цагааннуур сумд нэмэгдсэн. Цаг уур орчны шинжилгээний газрын сүүлийн 10 жилийн цаг агаарын мэдээ, статистик, мөн 2 жилийн хугацаанд тодорхой саруудыг хамруулан хийсэн 364 удаагийн хэмжилт туршилтын ажлын үр дүнгийн дунджаар хүйтний улиралд олгох шатахуун зарцуулалтын нэмэгдэл /хувь хэмжээг/ тооцсон болно.</p>

			<p>Туршилтын хугацаанд 2 автомашиныг тодорхой чиглэл, цагуудаар байнга ажиллуулж байсан бөгөөд нийтийн тээврийн автобус, ачааны автомашин, төрийн болон хувийн байгууллагын автомашинуудыг шатахуун зарцуулалтын туршилт, хэмжилтийн ажлын үр дүнд үндэслэсэн.</p> <p>Мөн хүйтний улирлын нэмэгдлийг орчны температур, авто замын нөхцөл байдал, автомашины хурд зэрэг үзүүлэлтэд тулгуурлан шатахуун зарцуулалтын өөрчлөлт, хувь хэмжээг тогтоосон.</p>
	<p>Хүйтний улирлын II бүсэд I ба III бүсэд харьяалагдаагүй аймаг, сум, Улаанбаатар хот багтсан байна. Хүйтний улирлын нэмэгдлийг 20 хувиар тогтоосон.</p> <ul style="list-style-type: none"> • 10 дугаар сарын 15-наас 5/ дүгээр сарын 15-ны хүртэл /+10/ хувиар; • 11 дүгээр сарын 16-наас 2 дугаар сарын 15-ныг хүртэл /+20/ хувиар; • 2 дугаар сарын 10-наас 4 дүгээр сарын 16-ныг хүртэл /+10/ хувиар тогтоосон байна. 	<p>Хүйтний улирлын II бүсэд I ба III бүсэд харьяалагдаагүй аймаг, сум, Улаанбаатар хот багтсан байна. Хүйтний улирлын нэмэгдлийг 20 хувиар тогтоосон.</p> <ul style="list-style-type: none"> • 10 дугаар сарын 15-наас 5/ дүгээр сарын 15-ны хүртэл /+10/ хувиар; • 11 дүгээр сарын 16-наас 2 дугаар сарын 15-ныг хүртэл /+20/ хувиар; • 2 дугаар сарын 10-наас 4 дүгээр сарын 16-ныг хүртэл /+10/ хувиар тогтоосон байна. 	<p>Хүйтний улирлын хугацааны хувьд 352 хөдөлгөөнийг зардалтай хувьд өөрчлөлтөөс орчны температурын өөрчлөлтөөс хамруулан туршилт, судалгааны ажлыг үндэслэн хувь хэмжээг шинэчилэн тогтоосон.</p>
	<p>Хүйтний улирлын III бүсэд Өмнөговь (бүх сум), Сүхбаатар (4 сум), Дорноговь (7 сум), Дундговь (4 сум), Баянхонгор (3 сум), Говь-Алтай (4 сум), Ховд (11 сум) аймгийн нутаг дэвсгэр багтсан. Хүйтний улирлын нэмэгдлийг.</p> <ul style="list-style-type: none"> • 11 дүгээр сарын 01-нээс 4 дүгээр сарын 01-нийг хүртэл /+5.0/ хувиар нэмэгдүүлэхээр тогтоосон. 	<p>Хүйтний улирлын III бүсэд Өмнөговь (бүх сум), Сүхбаатар (4 сум - 2), Дорноговь (7 сум + 2), Дундговь (4 сум + 2), Баянхонгор (7 сум + 1), Говь-Алтай (7 сум -5, + 3), Ховд (4 сум - 1, +1) аймгийн нутаг дэвсгэр багтсан.</p> <ul style="list-style-type: none"> • 11 дугаар сарын 1-нээс 11 дүгээр сарын 20-ныг хүртэл /+10/ хувиар. • 11 дүгээр сарын 21-наас 2 дугаар сарын 10-ныг хүртэл /+20/ хувиар; • 2 дугаар сарын 11-нээс 4 дүгээр сарын 1-ныг хүртэл /+10/ хувиар тогтоосон байна. 	<p>Сүхбаатар аймгийн Наран, Дарьганга сум хасагдаж, Дорноговь аймгийн Замын-Үүд, Дэлгэрэх сум, Дундговь аймгийн Гурвансайхан, Баянжаргалан сум нэмэгдсэн. Баянхонгор аймгийн Баян-Өндөр сум хасагдаж, Баацагаан сум нэмэгдсэн. Говь-Алтай аймгийн Тонхил, Бугат, Эрдэнэ, Цээл, Чандмань сумд хасагдаж, Шарга, Бигэр, Халиун сумд нэмэгдсэн. Ховд аймгийн Цэцэг сум хасагдаж, Зэрэг сум нэмэгдсэн байна. Цаг уур орчны шинжилгээний газрын суулийн 10 жилийн цаг агаарын мэдээ,</p>

			<p>статистикийн судалгаанд үндэслэн сумдыг нэмж, хассан болно. Дэлхийн цаг агаарын дулаарал нь Монгол орны цаг агаарын байдалд ч нөлөө үзүүлж байна.</p> <p>Хүйтний улирлын нэмэгдлийг орчны температуртай уялдуулан өөрсдийн хийсэн болон өмнө нь хийж байсан туршилт судалгааны дүнд дүйцүүлэн тогтоосон.</p>
			<p>Хүйтний улирлын IV бүсэд багтаж байсан Улаанбаатар хотыг хүйтний улирлын II бүсэд багтаасан. Автомашины шатахуун зарцуулалтын нэмэгдүүлэх хувь нь ижил учир тусгайлан бүсчлэх шаардлагагүй. Одоогийн мөрдөгдөж буй тушаалд Улаанбаатар хотыг бүсчлэн өргөсгөж ялгаж тодруулах байдлаар IV бүс гэж тусгайлан оруулсан болно.</p>
		Хасагдсан.	
	<p>Хүйтний улирлын IV бүсэд Улаанбаатар хотыг багтаасан. Хүйтний улирлын нэмэгдлийг.</p> <ul style="list-style-type: none"> 10 дугаар сарын 15-наас 4 дүгээр сарын 10-нийг хүртэл /+5.5/ хувиар нэмэгдүүлэхээр тогтоосон. 		
5.	<p>Ажил үйлчилгээний онцлог, авто замын онцгой хүнд нөхцлийг харгалзан автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх тусгай нөхцлүүдэд нийт 9 нөхцлийг авч үзсэн байна. Нэмэгдлийн хэмжээг 5-25 хувиар тогтоосон.</p>	<p>Ажил үйлчилгээний онцлог, авто замын онцгой хүнд нөхцлийг харгалзан автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх тусгай нөхцлүүдэд нийт 10 нөхцлийг авч үзсэн байна. Нэмэгдлийн хэмжээг 10-25 хувиар тогтоосон.</p>	<p>Улаанбаатар хотын дотор цагдаагийн байгууллагын тусгай үүрэг чиглэлийн автомашины нөхцлийг нэмж тусгасан.</p>
5.1	<p>Шинэ автомашин, шинэ хөдөлгүүрийн ашиглалтын эхний 1000 км гүйлтэд шатахууны үндсэн нормыг нэмэгдүүлэх хэмжээг 5 хувиар тогтоосон.</p>	<p>Шинэ автомашин, шинэ хөдөлгүүрийн ашиглалтын эхний 1000 км гүйлтэд шатахууны үндсэн нормыг нэмэгдүүлэх хэмжээг 10 хувиар тогтоосон.</p>	<p>Дэлхийн улс орнууд шинэ хөдөлгүүрийн зүгшрүүлэлтийн шатахуун зарцуулалтын нэмэгдлийг 10 хувиар тооцдог. Энэхүү үзүүлэлтэд үндэслэн, жишиг болгож авсан болно.</p>
5.2	<p>Замын хөдөлгөөний эрчим ихтэй Улаанбаатар хотод ажиллах автотээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх хэмжээг 5 хувиар тогтоосон.</p>	<p>Замын хөдөлгөөний эрчим ихтэй Улаанбаатар хотод ажиллах автотээврийн хэрэгслийн шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх хэмжээг 20 хувиар тогтоосон.</p>	<p>Улаанбаатар хотын өнөөгийн замын хөдөлгөөний ачаалалд үндэслэн туршилт, хэмжилтийн аргын үр дүнг үндэсдэн тогтоосон. Улаанбаатар хотын замын хөдөлгөөний ачаалал сүүлийн 20 жилд 65 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p>

5.3		<p>"Улаанбаатар хотын дотор цагдаагийн байгууллагын тусгай үүрэг чиглэлийн автомашинд үндсэн нормыг 25 хувиар нэмэгдүүлнэ" гэсэн заалтыг нэмж тусгасан. Энэхүү нэмэгдлийг тооцсон тохиолдолд Улаанбаатар хотын замын хөдөлгөөний эрчмийн нэмэгдлийг давхардуулан тооцохгүйгээр төсөлд тусгасан.</p>	<p>УБ хотод авто замын хөдөлгөөнд оролцож буй автомашины шатахуун зарцуулалтыг хөдөлгөөний эрчмээс хамааруулан 20 хувиар нэмэгдүүлэхээр төсөлд заасан. Цагдаагийн байгууллагын тусгай үүрэг чиглэлийн автомашины хувьд 25 хувиар нэмэгдэл авахаар заасан боловч дээрх Улаанбаатар хотын хөдөлгөөний эрчмийн нэмэгдлийг давхар тооцохгүйгээр тусгасан нь цагдаагийн байгууллагын ажил үүгийн онцлог байдлаас хамааруулан 5 хувийн нэмэгдлийг авахаар тусгасан. Энэхүү 5 хувийн нэмэгдэл нь гэр хорооллын ердийн хөрсөн замд ажиллах, хорооллын доторхи авто замд бага чиглэлийн автомашинуудтай болох нь туршилтаас тогтоогдсон. Туршилт судалгаанд цагдаагийн байгууллагын автомашинуудыг хамрагдсан бөгөөд холбогдох тайланг цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн болно.</p>
6.	<p>Автомашины 100 тнкм тээврийн ажлын болон өөрөө буулгагч автомашины ачаа буулгахад зарцуулах шатахууны норм</p>	<p>Нэмэлт өөрчлөлт ороогүй. Хэвээр мөрдөгдөнө.</p>	<p>-</p>
7.		<p>Тусгай тоноглол бүхий автотээврийн хэрэгслийн 100 км гүйлтэд зарцуулагдах шатахуун зарцуулалтын нормыг шинээр тусгасан.</p>	<p>Тусгай тоноглол бүхий 1 марк загварын автомашины нэмэгдэл төхөөрөмж өөр өөр /өргөх, чирэх, шахах... / байхаас гадна, зарим тусгай төхөөрөмж нь автомашины хөдөлгүүрээс ажилладаг бол зарим нь тухайн төхөөрөмжийг ажиллуулах нэмэгдэл хөдөлгүүр сурилагдсан байдаг. Иймд жишиг нормыг автомашины марк загвараар тогтоох боломжгүй тул шатахуун зарцуулалтын 1 мото цагийн нормыг зарцуулалтын 1 мото цагийн нормыг</p>

			<p>хэрхэн тооцох талаар заавар, зөвлөмж боовсруулан тусгасан.</p> <p>Тусгай тоноглол бүхий автомашиныг 1 мото.цагийн шатахуун зарцуулалтын жишиг нормыг тогтоох зааврыг иргэд, байгууллагын хүсэл байнга ирдэг тул уг нормын төсөлд шинээр нэмж тусгах шаардлагатай гэж үзсэн.</p>
<p>8.</p>	<p>Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар</p>	<p>Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох зааварт тусгагдсан томъёо, тайлбар, аргачлалыг энгийн хялбар болгох үүднээс "Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ"-г тус бүрт нь тодорхойлж шинэчлэн боловсруулсан. Өмнөх хувилбараас илүү ойлгомжтой, аливаа байгууллага, аж ахуйн нэгжүүдийн санхүү, нягтлан бодохын ажилтнууд гарын авлага болгон үргэлжлээр боловсруулагдах</p>	<p>Шатахуун зарцуулалтын жишиг болон үндсэн норм тогтоох аргачлалаас эхлээд төсөлд тусгагдсан шатахуун зарцуулалтын нэмэгдлүүдийн дараалал агуулгаар нэг бүрчлэн аргачлал, зөвлөмж, тайлбар жишээг ойлгомжтой энгийн болгох тал дээр анхааран боловсруулсан болно.</p>
<p>9.</p>	<p>Автомашины эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг нормыг автомашины марк, загвар бүрээр жагсаалтаар гаргасан. Уг жагсаалтад 620 тээврийн хэрэгсэл багтсан. Автомашины эдэлгээний нөөцийн доод хязгаар, гүйлтийн нормыг тогтооход харгалзах нөхцлүүдийг тусгасан.</p> <p>Автомашины эдэлгээний нөөцийн доод хязгаар, гүйлтийн нормыг тогтооход авто замын нөхцөл, автомашины төрлөөс хамааруулан тооцсон.</p> <p>Авто замын нөхцөл, автомашины төрөл, ачааллаас хамааруулж, 5-25 хувь хүртэл хорогдуулж тооцохоор тогтоосон байна.</p>	<p>Тухайн автомашины үйлдвэрлэгчийн автомашины эдэлгээний гүйлтийг судлан суудлын автомашин, ачааны автомашин, автобус гэсэн ангиллаар, тээврийн хэрэгслийн маркаар жишиг нормыг тооцсон.</p> <p>Автомашины эдэлгээний нөөцийн доод хязгаар, гүйлтийн нормыг тогтооход авто замын нөхцөл, автомашины төрлөөс хамааруулан тооцсон.</p> <p>Авто замын нөхцөл, автомашины төрөл, ачааллаас хамааруулж, 5-25 хувь хүртэл хорогдуулж тооцохоор тогтоосон байна.</p> <p>Автомашины төрөл, ачааллаас хамааруулж автомашины эдэлгээний гүйлтийн нормыг тооцохдоо цагдаагийн байгууллагын тусгай үүрэг чиглэлйн автомашиныг нэмж тусгасан ба хорогдуулах хувийг 20 гэж тооцсон.</p>	<p>Автомашины эдэлгээний нөөцийн доод хязгаар, гүйлтийн нормыг үйлдвэрлэгчээс тогтоосон эдэлгээний нөөцийг шууд мөрдөх бөгөөд манай орны ашиглалтын нөхцөлийг тусган өсгөх буюу бууруулах ямар нэгэн коэффициент байхгүй тул жагсаалтаар гаргах шаардлагагүй гэж үзсэн.</p> <p>Цагдаагийн байгууллагын тусгай үүрэг чиглэлйн автомашинуудын техникийн баримт бичиг, засвар үйлчилгээний түүх, сэлбэг, материалын санхүүгийн баримт бичгийг үндэслэн судалгааны аргаар өөрчлөлтийн хувь хэмжээг тогтоосон.</p>
<p>10.</p>	<p>Резинэн дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаар буюу гүйлтийн нормыг уур амьсгал, авто замын нөхцлийг харгалзан тогтоосон ашиглалтын бүсээс хамааруулан 10 хувиар хорогдуулан тооцохоор</p>	<p>Резинэн дугуйн эдэлгээний гүйлтийн доод хязгаарын жишиг нормд нэмэлт өөрчлөлт ороогүй. Хэвээр мөрдөнө. Мөн нормд тусгагдаагүй резин дугуйн гүйлтийн нормыг</p>	<p>Цагдаагийн байгууллагын тусгай үүрэг чиглэлйн автомашинуудын техникийн баримт бичиг, засвар үйлчилгээний түүх, сэлбэг, материалын санхүүгийн</p>

	<p>тусгасан. Тээвэрлэлтийн нөхцлөөс хамаарч мөн резин дугуйн эдэлгээний гүйлтийн нормыг 15-30 хүртэлх хувиар хорогдуулан тооцсон байна.</p>	<p>автомашинны резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн жишиг нормыг үндэслэн өөрсдөө тогтоож мөрдөхөөр зааж өгсөн.</p> <p>Тээвэрлэлтийн нөхцлөөс хамаарч мөн резин дугуйн эдэлгээний гүйлтийн нормыг 15-30 хүртэлх хувиар хорогдуулан тооцох зэрэг ашиглалтын нэмэгдлүүдийг хэвээр үлдээсэн. Цагдаагийн байгууллагын автомашинд ердийн хөрсөн зам болон автозамын сэнгэй хүнд нөхцөлд резин дугуйн эдэлгээний гүйлтийн нормыг 25 хувиар хорогдуулж тооцохоор тусгасан.</p>	<p>баримт бичгийг үндэслэн судалгааны аргаар тогтоосон.</p>
<p>11.</p>	<p>Зай хураагуурын эдэлгээний хугацааны доод хязгаарын жишиг нормыг тогтоохдоо зай хураагуурын эдэлгээний хугацааны доод хязгаарын жишиг нормыг зай хураагуурын төрөл, үйлдвэрлэсэн улсаар ангилан сараар тогтоосон.</p>	<p>Зай хураагуурын эдэлгээний хугацааны доод хязгаарын жишиг нормыг үйлдвэрлэгчээс тогтоосон эдэлгээний хугацааны доод хязгаарыг үндэслэн зай хураагуурын үндсэн нормыг тогтоохоор тусгасан. Ашиглалтын хугацаанд автомашины нэмэгдэл төхөөрөмж хөдөлгүүр унтраасан үед зай хураагуураас тэжээл авч ажиллах нөхцөлд нэмэгдэл төхөөрөмжийн /GPS, дохиолол, тог хувиргагч г.м/ тооноос хамааруулан зай хураагуурын эдэлгээний нормыг 50 хүртэл хувиар бууруулан тооцож болохоор тусгасан.</p>	<p>-</p>
<p>12.</p>	<p>Суудлын автомашин, автобус, ачааны автомашинны үндсэн агрегат, зангилаануудын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг нормыг тогтоосон. Үндсэн агрегат, зангилаанд автомашины хөдөлгүүр, авцуулах холбоо, хурдны хайрцаг, хөтлөгч ба урд тэнхлэг, жолооны удирдлага, ачааны автомашинны кабин, суудлын автомашин, автобусны кузов зэргийг багтаасан.</p>	<p>Нэмэлт, өөрчлөлт ороогүй. Ойлгомжтой болгох үүднээс найруулга, хүснэгтийг өөрчилсөн.</p>	<p>-</p>

АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗАР



ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот


Хуралдаан 2018 оны 12 дугаар сарын 07-ний өдрийн 10.00 цагт Зам, тээврийн хөгжлийн яамны 301 тоот хурлын зааланд болж, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх, уг зөвлөлийн дэд дарга Ц.Цогтбаатар удирдан явуулж, доорх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүнд:

Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг шинэчлэн боловсруулсан судалгааны ажлын эцсийн тайлан


Шийдвэрлэсэн нь:

1. "Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг судалгаа"-ны ажлын эцсийн тайланг дэмжив.
2. Зөвлөлийн гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийг судалгааны ажлын тайланд тусган Захиалагчид ирүүлэхийг "Зам тээврийн хүрээлэн" НҮТББ /О.Оюунбат/-д даалгав.
3. Шинэчлэн боловсруулсан жишиг нормыг Зам тээврийн хөгжлийн сайдын тушаалаар батлуулж, мөрдүүлэхийг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Батболд/-т үүрэг болгов.


Хурлын тэмдэглэлтэй танилцсан:
УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн,
Зам, тээврийн хөгжлийн сайд бөгөөд
Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн
дарга

 Я.СОДБААТАР

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:
Зам, тээврийн хөгжлийн сайдын Зөвлөх бөгөөд
Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дэд
дарга

 Ц.ЦОГТБААТАР

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:
ЗТХЯ-ны БТГ-ын СНХ-ийн ахлах мэргэжилтэн,
ШУТЗ-ийн нарийн бичгийн дарга,
Доктор /PhD/, Монгол Улсын
Зөвлөх Инженер

 Д.ГЭРЭЛНЯМ